

“ЦЭРЭНПИЛИЙН ХЭРЭГ”-Т ХОЛБОГДОХ БАРИМТУУДЫГ НЭХЭН ЭРЭГЦҮҮЛЭХҮЙ

Хэрээд Ж.УРАНГУА, Л.ОДЗАЯА

Товч агуулга: Монгол оронд Ардын засаг тогтоод удаагүй байсан үе буюу 1922-1923 онуудад Монгол, Хятад, Япон гурван улсыг дамнасан нэгэн хэрэг буюу манай түүх бичлэгт “Цэрэнпилийн хэрэг” хэмээн тэмдэглэгдэн хэргийн талаарх өмнөх судалгааг хураангуйлан тоймлохын зэрэгцээ эл хэрэгт холбогдох нэгэн шинэ баримтыг танилцуулж байна. Тухайлбал, Япон улсын Гадаад хэргийн яамны Архивд хадгалагдаж буй “Олноо өргөгдсөний 12 он усан нохой жилийн намрын тэргүүн сарын 25-ны өдөр Монголын аймаг савыг баригч Ачит номун Донхор Манзушир хутагт батлан гарын үсэг зурсан Японы эзэн хаанд илгээсэн “Өргөх бичиг” болон уг өргөн дэвшүүлэх нугалбарыг дагалдуулан илгээсэн “Монгол улсын Олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны арван нэгэн сараас эхлэн Ардын засагт хэмээх олон нам Оросын Москва хотноо хуралдсан Залуучуудын эвлэлийн хүмүүсийн зөвлөлдөн хэлэлцсэн саналын хуулбар”¹ зэрэг тухайн үеийн Монголын нийгмийн зарим давхаргынхны үзэл санаа бодол, үйлдлийн толь болсон эх сурвалжийг шинжлэн үзэв. Улмаар өгүүлэлийн төгсгөлд, Японы эзэн хаанаас тусламж хүсэн илгээсэн захидлын ард хавсарган явуулсан баримтыг Японы Гадаад хэргийн яамны Архиваас хуулбарлан авч, монгол бичгээс кирилл үсэгнээ буулгаснаа хавсаргав.

Түлхүүр үгс: Цэрэнпилийн хэрэг, Японы Гадаад Явдлын яамны архив, Манзушир хутагтын өргөх бичиг

¹ *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan*. The documents brought by the representative of the Living Buddha in Outer Mongolia. Reference Code: B03050172300. Subseries Key B-1-6-1-142. pp.511329-511383. Үүний 51132-51141-р тал нь захидал, т.51142-511383 дагалдуулсан баримт болно. Захидлыг анх 1970 онд Онон Өргөнгө дээрхи архиваас олж, хуулбарлан аваад улмаар *INNER ASIA. Occasional Papers. Volume 1, Number 1, 1996. Mongolian and Inner Asia Studies Unit. University of Cambridge* сэтгүүлийн 71-78-р талд захидлын эхийг болон түүний англи орчуулгыг нийтлүүлжээ. Өргөх бичигт хавсаргасан материалыг тэрбээр олж үзээгүй байна. *Urgunge Onon. On document from Office of Diplomatic documents Japanese Foreign Ministry*. Түүхч Э. Чимидцэрэн Их Британы Лидсийн их сургуульд багшилж байх үед Онон Өргөнгө Японоос авчирсан дээрх захидалтай танилцаад “Монголын феодалуудын нэгэн хуйвалдааны тухай шинэ баримт” өгүүлэл бичжээ. МАХН-ын түүхийн асуудал. Эрдэм шинжилгээний өгүүллтийн эмхтгэл №10. УБ., 1974, т.190-194. *Мөн судлаач О.Батсайхан бээр* Цэрэнпил гүнгийн хэргийн тухайд. УБ., 2006 номондоо, Цэрэнпилийн захидлын эх болон түүнийг кирилл үсэгнээ буулгаснаа хэвлүүлж улмаар Цэрэнпилийн хэргийн тухайд Монголд явуулсан үйл ажиллагааны талаар болон Японы Гадаад хэргийн яаманд хадгалагдаж буй зарим мэдээлэл зэргийг оруулсан байна. Тэрээр Өргөх бичгийг дагалдуулан өргөсөн баримтанд төдийлөн анхаарал хандуулсангүй. Гагцхүү түүний гарчигийг бичээд, тайлбар хийхдээ түүнийг Залуучуудын коммунист Интернационал \КИМ\ -ээс гаргасан тунхаглал хэмээн бичсэн нь ташаарсан зүйл болжээ.

1. “Цэрэнпилийн хэрэг” гэгчийн учиг

Монгол оронд ардын эрхтэй, хэмжээт цаазат засаг тогтоод нэгэн жилийн нүүр үзэж байтал Ардын засгийг түлхэн унагааж, Шашин төрийг хослон барьсан хаант засгийг дахин тогтоохыг хүсэн эрмэлзэгч хүмүүс Япон улсын эзэн хаанд хандан тус улсаас тусламж хүссэн бичгийг үйлдэж, 1923 оны 5 сард Японы Гадаад хэргийн яамнаа гардуулан өгчээ. Бидний үе хүртэл хадгалагдан ирсэн баримтуудыг сөхөн үзвээс, 1922 оны дунд үеэр Ардын засгийн бодлого хийгээд тэдний засаглалыг эсэргүүцсэн үзэл санаа бүхий хүмүүс Хятад, Япон зэрэг гадаад орнууд руу хандан тусламж эрхийг санаархах явдал удаа дараагарч байсан² агаад өгүүлэн буй үед Шүүх яамны Гадаад хэлтсийн жинхэнэ бичээчээр ажиллаж байгаад 1922 оны зун ажлаасаа чөлөө аваад³ Манжуур зэрэг газраар улс төрийн хэргээр одсон Цэрэнпил гүн⁴ Японоос тусламж гуйх бичгийг төлөвлөн зохиож⁵, түүнийгээ хүргэхээр одсон нэгэн хэрэг гарч эл тухайд тэр үед ихэд шуугиан дэгдээж, ул хэргийн мөрөөр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж, хэрэгт холбогдсон олон⁶ хүн шийтгүүлсэн хэрэг болжээ. Япон улсаас тусламж эрэхээр хэдэн хүн хил даван одсонг тэр үеийн Монголын нам, засгийн удирдагчид болон зарим нэгэн нөлөө бүхий хүмүүс мэдсэн байжээ. Тэдний дунд Цэрэнпил байна гэдгийг тэр даруй мэдсэн бололтой. Учир нь сонор сэрэмж алдсан гэж Зүүн хязгаарын сайд болон намын төлөөний түшмэлийг өвлийн дунд сард Нийслэлд дуудан байцахад тэд Цэрэнпилийг хил даван гарсаныг Дотоодыг хамгаалах газарт мэдээлсэн гэдгээ илтгэсэн баримт байна⁷. Мөн Сүхбаатар жанжин нас нөгчихийн урьд өдөр⁸: “... өнөөх Цэрэнпил этгээд нар...цагаан сараар...дашрамдуулж ...хөдлөх болов уу... ихэд сэжиглэнэ” хэмээн хэлсэн гэж Л.Дэндэв тэмдэглэн үлдээжээ.⁹ Ингээд 1923

² Олноо өргөдсөн Монгол улсын Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны сайд, да лам Г. Цэрэнчимид Японыг зорьсон (хүрч чадаагүй), Сайн ноён хан Т.Намнасүрэн захидал илгээсэн (Японы Гадаад хэргийн яамны Архивт хадгалагдаж буй), 1921 оны 5 сард Японтой холбоо тогтоохыг оролдсон (бүтэлгүйтсэн), 1922 онд энэ Цэрэнпилийн захидал (Японы Гадаад хэргийн яамны Архивт хадгалагдаж буй) мөн хойтон жил нь Барон Унгерны цэрэгт алба хааж явсан орос Гомбо гэгч Японоос тусламж хүссэн захидал үйлдэн (илчдэгдсэн) хийсэний сүүлийн хоёрт нь Цэрэнпилийн хамсааган Цэвээнноров оролцсон байна. Мөн зарим номонд Сэцэнхан аймгийн гүн Гүррагчааг Японд илгээж байсан тухай мэдээ мөн буй.

³ 1922 оны 3 сарын 27-ны орчмоос 6 сарын 9-ны хооронд буюу 2 сар 15 хоног ажилласан хэмээн О.Батсайхан тооцолон гаргажээ. Дурьдсан зохиол, т.41-42

⁴ Цэрэнпилийг олон судлаачид Сэцэн хан аймгийн Ачит вангийн хошууны хүн гэж бичсэн байдгийг О.Батсайхан үгүйсгэсэн нь буй. Дурьдсан зохиол, т.38. С. Баттогтох, Цэрэнпилийн эцэг нь цагаан намын баян буриад хүн байсан хэмээжээ. Дурьдсан зохиол, т. 86

⁵ Энэхүү хэргийг анх арван хэдэн хүн зөвлөн сэдсэнгэж Дилав хугагт Жамсранжав бичжээ. “Ар Монголын улс төрийн дурьдгал” УБ., 1991 он. Соёмбо, т.47

⁶ Эл хэрэгт 30 орчим хүн оролцсоны баригдан байцаагдсан хүний тоо 25 хэмээн О.Батсайхан бичжээ. Дурьдсан зохиол, т.36

⁷ Баттогтох С.Нууц хуйвалдаанаас нугалаа завхралд. УБ., 1991, т.89-90

⁸ 1923 оны цагаан сарын шинийн 5-ны үүрээр

⁹ “Сүхбаатарын тухай дуртгалууд”. УБ., 1965, т75

оны 5 сарын 23-ндэл хэргийг илчлэн мөрдөн байцаах тусгай комисс¹⁰ байгуулагдан ажилласан байна.

Чухам яагаад Япон улсаас тусламж хүсэх болов хэмээвээс тус улс нь эл үед нэн их хурдацтай хөгжиж буйг монголчууд сайн мэдэж байсан агаад Дорнын хүчирхэг түүн рүү хандахыг хүссэн байна. XX зууны эхний 20 жилд Японы аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2 дахин нэмэгдэж, алтны нөөц нь 350 сая иенээс (1914) 2млрд иен (1919) болж өссөн; экспортын хэмжээ 1913 онд 653 сая иен байсан бол 1918 онд 1 962 сая иен болсон ба импортын хэмжээ мөн энэ хугацаанд 729 саяас 1.668 сая иен болжээ. Мөн Англи, Франц, Орост 500 сая иений зээллэг (1917 оноос өмнө) олгосон байна¹¹. Тэр үед Монголд олон улсын байдлыг гадарлах хүмүүс байсан агаад тэд Орос оронд ажилчин тариачны Зөвлөлийн засаг тогтоод Оросын Хаант засгийн үеийн бүх гэрээ хэлэлцээрийг хүчингүй болгосон мэдэж байсан учир урьдын цагт Хаант Орос улс Японтой Ази дахь нөлөөнийхээ хүрээг зааглан тогтоож байсан гэрээ хэлэлцэлүүд¹² (1907, 1910, 1912, 1916 оны) нэгэнт хүчингүй болсон нь Япон руухандах үүд зам нээгдсэн хэмээн бодож, үүнд нь олон улсын харилцааны зүгээс харшлах зүйлгүй хэмээн үзэж, энэ завшааныг ашиглахаар тооцоолон хөдөлсөн болов уу¹³. Гэвч тэд нэгэн зүйлийг тооцолсонгүй мэт аж. Тэр нь олон улсын хэмжээнд Монгол улсыг Хятадын эзэн эрхийн дор орших орон хэмээн үзэж байсан явдал билээ. Тиймээс ч эл байдлын улмаас Япон улс Монголд тусламж үзүүлэх боломж байгаагүй бөгөөд Япон ч үүнийгээ тухайн үед ил тод мэдэгдэж байсныг хожим өгүүлэх болно.

Ингээд Цэрэнпилийн хэрэгт холбогдон шийтгэгдсэн хүмүүс нь төрийн яам, хошуу нутгийн албаны түшмэл хийгээд лам зэрэг Монголын нийгмийн янз бүрийн давхаргын төлөөлөл байв. Байцаагдсан хүмүүсийн хоёр нь Япон руу одсон Цэрэнпил, Цэвээнноров нарын хэрэг бүтэмжтэй болсон, тэр хоёр нэгэн хятад ноёныд байгаа гэх мэтчилэн мэдүүлснээс үзэхэд тэд үйл хэргийн явцын талаар тодорхой мэдээлэл авч байсан нь харагдана. Гэвч тэр үед Ардын засгийнхан Япон руу илгээсэн захидыг агуулгыг там тум гадарлаж байжээ. Мөн эл хэргийн цаанаа хуучин эрх дархаа алдсан гэх нөлөө бүхий хүмүүс байсан хэмээн үзсээр ирсэн бөгөөд чухам хэн хэн байсныг өдгөө хүртэл илрүүлж чадахгүй байгаа билээ.

Түүнчлэн Өргөх бичиг чухам ямар замаар Японд хүрсэн болон чухам

¹⁰ УТА Ф.284, д1, хн 111, х.2

¹¹ Ефимов Г.В., Дубинский А.М. Международные отношения на Дальнем Востоке. Книга вторая 1917-1945 гг. Москва. Мысль. 1973, т.13

¹² Эдгээр гэрээ хэлцэлээр Гадаад Монгол нь Хаант Оросын нөлөөний бүс, Өвөр Монголыг Японы нөлөөний бүс хэмээн тогтоосон байсан.

¹³ Дилов хутагт Жамсранжав өөрийн дурьдатгал номондоо: “1919 оны өвөл Цогтбадамжавын зэрэг хэдэн буриад хүмүүсээс Япон улсаас тусламж эрвэл амар түргэнээр тусалж чадмой... монголчууд урдаас Япон улс колони улсыг туйлын харгисаар дарласан хэмээн сонссон тул түүний харгисаас бэрхшээж, дурлах хүн гарсангүй” хэмээн тэмдэглэн үлдээсэн нь мөн буй. *Дилав хутагт Жамсранжав. Ар Монголын улс төрийн дуртгал. УБ., 1991, т.21.*

хэн түүнийг хүргэж өгсөн нь одоогоор тодорхойгүй хэвээр байна. Дээр дурдсан судлаач О.Батсайхан хувь хүн хүргэж өгсөн гэжээ. Монгол улсын тагнуулын албаны түүхнээ “Гадаад тагнуулын анхны арга хэмжээ” гэж нэрлэн эл хэргийн тухайд,

“Шүүх явдлын яамны бичээч Д.Цэрэнпил нь Балдан, Цэвээнноров нарын хэсэг хүмүүсийн хамтаар Япон улсаас тусламж авч, Ардын засаг төрийг устгах хуйвалдаан зохион байгуулсан нь.... Монгол,Хятад, Япон улсыг дамжин гурван жил үргэлжилж, олон хүнийг хамарсан уг хуйвалдааныг илрүүлж, таслан зогсоох арга хэмжээг Дотоодыг хамгаалах газар..... амжилтай зохион байгуулжээ....Цэрэнпилийн захидлыг Японы тал хүлээн авсан боловч тусламж үзүүлээгүй юм”

хэмээн бичсэн байна.¹⁴

Социалист байгуулалтын жилүүдэд Цэрэнпил тэргүүтэй Монголын нийгмийн дундач давхрага болох түшмэл, лам нар эл хэрэгт холбогдсон гэдгийг тогтоон баривчилж, мөрдөн байцааж, ял шийтгэл оноосон хэдүй ч эл хэргийн цаана Монголын ихэс дээдэс асан, ард түмний дунд нөлөө бүхий хүмүүс байна хэмээн үзсэн байна. Тухайлбал, 1923 онд хуралдсан Монгол Ардын намын их хуралд Намын Төв хорооноос тавьсан илтгэлд хийсэн тайлбарт,

“Япон улсаас тусламж олох гэдэг нь Монголын том феодалуудын зарим хэсэг нь Япон улсын ивээлдорохоор эрмэлзэж 1920 оны дунд үеэс Япон улстай хэлхээ холбоо тогтоох, тусламж дэмжлэг олох, хэлэлцээ хийхээр арга хайж, 9 сард хэдэн феодалыг Хятадад байсан Японы консулын газарт нууцаар явуулж, тусламж гуйсан”¹⁵

хэмээжээ. Мөн 1925 онд “Олноо өргөгдсөний арванхоёрдугаар онд Манзшир лам, Довчин хувилгаан, Дамбийжанцан зэргийн хэд хэдэн хувилгаад нь ...ардын засгийг устгахыг эрмэлзэн Япон ба Хятадын эзэрхэг харгисуудаас тусламж гуйлгаж, Ачит вангийн хошууны бичээч Цэрэнпилийг томилсон бөлгөө” гээд цааш нь,

“эдгээр хутагт, хувилгаадын тэдгээр Япон, Хятадын харгис нараас тусламж ямар бодлогоор гуйсан болой хэмээсэн асууваас зохимуй. Санаваас мөнөөхөн тав гурван жилийн урьд манай Монгол газар сууж бүхийн зуураа тэдний харгис нар дацан хийдийг түймэрдэн шатааж бурхан номыг устгасан ба энгийн цэргүүд нь номын хавтсаар гутлын ул хийсэн ба хөрөг бурхан мөн номын жанч, баримтагаар хөлийн ороолт хийсэн харгис хэрцгий хүнийг дахин урин авчирч тэдний хүчээр Шарын

¹⁴ “Тагнуулын ерөнхий газар” Тэргүүн дэвтэр 1922-1962 он. УБ., 2011, 29

¹⁵ “Монгол Ардын намын хоёрдугаар их хурал. Баримт бичгүүд” УБ., 1974, 159

шашныг ариутган мандуулж ард түмэн улс төрөө жаргуулсугай хэмээн мунхагласан нь болов уу.¹⁶ Гэтэл өчүүхэн хүүхэд боловч тийнхүү Япон, Хятадын харгис нараар шашин төрөө хамгаалуулан мандуулна хэмээхийг итгэхгүй буй за. Адилтгаваас Япон, Хятадын харгис нараар шашин төрөө туслуулсугай хэмээсэн нь умдаасан бүхий хүмүүст халуун хярам уулгасантай адил болох биш үү. Басхүү тэдгээр хувилгаадудаар ард түмнээ хэрхэн жаргуулсугай хэмээсэн болой хэмээвээс үүний тухайд мөнөөхөн томилогдсон Цэрэнпэлийн харьяат вандаа бичсэн захидлын дотор өгүүлсэн нь, Ардын засгаар ноён, боол хоёрын заяаны хэлхээ холбоог эвджээ. Ард түмний тусыг бодож хуучны холбоог нь сэргээн бадруулаас зохино хэмээсэн бөгөөд мөн энэхүү үгийг японы хаан ба хятад нэгэн жанжин бөгөөд хулгайн явсан Жан Золиндилгээсэн бичгийн дотор мөн өгүүлэгдсэн болой¹⁷

гэж тухайн үед бичиж байснаас үзэхэд, Цэрэнпил тэргүүтэй хүмүүсийн цаанаа хутагт хувилгаад байна хэмээн үзэж байв. Түүнчлэн Ардын засгийн эсрэг үзэлтнүүдийг чухам яагаад ард түмнийг жаргуулах эл засагт дургүй байгааг мэдэх гэсэн ба мөн Хятад, Япон улсад хандах нь зохисгүй хэмээн ухуулан сэнхрүүлэхийг оролдсон байна.

Гэвч эдгээр орнуудруу Монголчуудын зарим нэгэн хэсэг хандаж байсныг нотлох баримтууд өдгөө хадгалагдан үлджээ. Японы Гадаад хэргийн яамны Архивт хадгалагдаж буй баримтыг үндэслэвэл, 1922 оны 1 сарын 13—нд Мүгдэн дэх Японы төлөөлөгч Гадаад яамандаа Мүгдэнгийн сэргийлэх газрын даргаас авсан мэдээлэлийн дагуу Монголын Богдхааны нэрийн өмнөөс Хятадын цэргийн эрхтэн Чжан Цзолинд хандан, “Оросууд монголчуудыг дарангуйлж байгаа байдлыг Хятадын төв засгийн газартаа мэдээлж өгнө үү” гэсэн бичгийг 1922 оны 1 сарын 12-нд ирүүлсэн хэмээх дам мэдээг дамжуулсан байна.¹⁸

Тухайн үед Цэрэнпилийг Хятад болон Японоос тусламж гуйх бичгийг үйлдсэнийг нотлон өгсөн хэрэгт холбогдон байцаагдсан хүмүүсийн мэдүүлэгээс үзэхэд, ардын засгийг устгаж хуучин овог язгуурын ёс журмыг тасралтгүй болгохын тулд цэрэг, зэвсгийн тусламж хүссэн бичгийг анх 3 хүн үйлдсэн боловч хоршосон нь мөн байв, бичгийг гурван хувь үйлдэх \Манзуширийн өгсөн зөвлөмж\¹⁹, ардын засгийг устгахаар цэрэг урин ирүүлхээр Нархажидыг явуулсан²⁰, Манзушир

¹⁶ Энд хятадуудыг хэлж байна

¹⁷ *Монгол Ардын Хувьсгалт Намын тогтоол шийдвэр баримт бичгүүд. Нэгдүгээр боть /1920-1928 он/ УБ., 1981, тал 265-272*

¹⁸ *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan*. Reference Code: B03041574000

¹⁹ Энэ тухайд үзвээс, Хэрэгт холбогчдын мэдүүлэгт: нэг бичгийг Чойбалсан цэрэг аван зүүн зүг хөдөлсөн гэдгийг сонсоод шатаасан, мөн захидлын агуулгад тусгагдсан зүйл бичсэн бичиг бас түүнчлэн Манзушир хутагтын тамгыг дарсан шар торгон дээр захидлын үг үсгийг бичээд Цэрэнпил болон бас нэгэн ламын нэр бичсэн гадаадын улс дор нэвтрүүлхээр явуулав хэмээсэн үг бүхий зүйл үзсэн зэргийн талаар дурьдсан байна. УТА, Ф. 282, д.1, хн111, х.7

²⁰ Мүгдэнд суух Японы консулаас Гадаад яамандаа 1924 оны 1-р сард илгээсэн бичигт” Цэрэнпил

хутагттай зөвлөлдсөн, хувилгаан Довчин мөнгө зэрэг зүйлсээр тусалсан, Богд хаанд айлтгахыг оролдсон ба айлтгасан²¹, тусламж эрсэн бичгийг үйлдэхэд оролцсон, хэргийг нуун дарагдуулсан²², ажлын хариуцлага алдсан²³, Дотоодыг Хамгаалах газар, намын нөхдүүдээс мэдүүлсэн зэрэг эх адагт сааргүй холбогдогчдыг Магсаржав хурцын бичсэнчлэн, “ял янх дор холбогдон чирэгдсэн ард цлэмжхэн гарч, ...8 хүнийг буудан алах ял, ...4 хүнийг таван жил гянданд хорих, ...3 хүнийг гурван жил гянданд хорих, ... явсныг нь мэдсэн боловч нэхэж тагнуулдаагүй ба гэрчлэн эс гарсан албан тушаалтан нэр бүхий 6 хүнийг 270 лан мөнгөөр торгож тушаалаас байлгасан мөн гэрчлээгүй гэх... яланд 2 ардыг тус бүр 27 лан мөнгөөр торгох”²⁴ зэргээр шийтгэсэн байна. Магсар хурц мөн,

“Манзушир лам чухал холбогдсон боловч тэр өөрөө нэгэнт гэрчилэн гаргасан бусад нэр оролдогчид холбогдолгүй болсон тул ял хэлэлцэхийг хэрэгсэхгүй болгосугай хэмээсэн”²⁵

гэж бичсэн байна. Гэтэл Манзушир хутагт²⁶ 1937 онд Дотоодыг Хамгаалах Газарт өгсөн мэдүүлэгтээ,

“Цэрэнпил, Цэвээнноров нарын хэрэгт дуртайгаар зөвшөөрөн оролцож тэд нарын гадаадад аваачих (явуулах) албан ёсны бичиг дор өөрийн хутагтын тамгыг дарж өгөхөөр бэлтгэж байсан бөгөөд гэтэл тэр хэрэг биелэж тусыг олж чадсангүй илэрсэн тул миний бие тэр даруй дор Ардын Засгийн Газраас дуудагдан байцаагдаж уг өдүүлсэн хэрэгтээ байцаагдаж зохих ял шийдвэрийг хүлээн өнгөрсөн”²⁷

гэж Цэрэнпилийн хэрэг тусыг олж чадаагүй илэрсэн хэмээн бичсэн нь Японы тусламжийг олж чадаагүй мөн эл хэргийн нууцлал алдагдаж илэрсэн гэдгийг хүлээжээ. Түүнчлэн “Мөн сүүлд хэрэг үйлдэгсэд ял унагаж, Богд бид хоёрыг олны багш учир ял оногдуулсангүй өнгөрсөнд би их баярласан” гэж хэлсэн нь ярихдаа: одоо хутагт 4 аймгийн даргатай зөвлөлдөж, 15 000 цэргийг элсээж, улаан цэрэгтэй байлдахыг бодож байна” гэсэн тэмдэглэлийг эш татан О.Батсайхан “Цэрэнпил гүнгийн хэргийн тухай” номондоо бичжээ. Дурьдсан ном, т.7

²¹ Сэрээнэн оточ Богд хаантаа айлтгасан гэж Чадраабал мэдүүлсэн. УТА, Ф. 282, д.1, хн111, х.16-17

²² Тухайлбал, Луузангийн өчигт Шүүх явдлын яамны сайд бэйс Магсаржав, дэд сайд орлосон гүн Төртогтох нарт хэлхэд зөвшөөрсөн гэсэн нь буй. Үндэсний Төв Архив. Фонд 282, Данс 1, хадгаламжийн нэгж 111

²³ Зүүн хязгаарыг тохиуулах сайд Алтангэрэл, Ардын засгийн төлөөний түшмэл Гончигдаш нарыг баривчлан Нийслэл Хүрээнд авчирж байцаасан

²⁴ Магсаржав Н. Монгол улсын шинэ түүх. УБ., 2010, т.248

²⁵ Н.Магсаржав. Дурьдсан зохиол, т.249

²⁶ Богд хааны Их Шавийн хутагтуудын нэг. Нэгэн отогт хамаарах 300 гаруй шавьтай. 1929-1930 онд хөрөнгийг нь хураасан. Манзушир хийд Богд уулын өвөрт оршино. 1750 онд байгуулагдсан. 1791 онд “Буяаны залбирагч сүм” нэр хүртээжээ.

²⁷ ТЕГ. Тусгай Архив. Ц-1603 Манзушир хутагт Цэрэндоржийн хэрэг. 27(1937) оны 9 дүгээр сарын 23, Мэдүүлэг-6

Тагнуулын ерөнхий газрын Архивд хадгалагдан “Цэрэнпилийн хэргийн хуулбар”²⁸ гэсэнд хадгалагдаж байгааг судлаач С.Баттогтох эш татжээ.

1920-1930 оны үйл явдлын нэгэн гэрч болох Дилав хутагт Б. Жамсранжав 1949 онд бичсэн “Ар Монголын улс төрийн дурьдатгал” зохиолдоо,

”Мөн өвлийн дунд сард Ширнэн оточ, Балдан гүн, Хажидын хувилгаан, бичээч Цэрэнпил, Цэвээноров нарын зэрэг арван хэдэн хүн зөвлөн Япон ба Хятадаас тусламж эрж эв хамтыг устгахаар Манзширламын тамга дарсан бичгийг авч хязгаар нэвтрэн явах замдаа Угтамын лам хэмээх Довчин хувилгааныг дайрч учраа хэлж улаа хэрэглэлийг сэлбэн авч нэвтрэн явсан нь мэдэгдэж Ширнэн нар баригдсан”

гээд Манзушир хутагтыг болохоор Жалханз гэгээн ба сайд Цэрэндорж нараас тэрбээр урьдчилан Мишигдоржламд мэдээлж байсан учраас хэмээн өмгөөлсөнд Манзушир хутагт ялд орсоогүй хэмээн Дилав хутагт бичээд цааш нь:

“Энэ үест эв хамтын засгийг шинэхэн үүсгэн явуулж үндсэн суурь бэхжиж чадаагүй тул Манзшир ламд халдваас хүрээ хорооны лам нар, хар бүгд босож эсэргүүцэхээс айснаар тийнхүү өнгөрөөжээ”²⁹

хэмээн бичсэн үнэнд бүрнээ нийцэх бөлгөө.

1974 онд түүхч Э.Чимидцэрэн Английн Лидсийн Их Сургуульд 1 жил очиж судалгааны ажил хийх үедээ Японы Гадаад хэргийн яамны Архивд хадгалагдаж байгаа дээрхи захидлыг Онон Өргөнгөгөөс хуулбарлан аваад нэгэн илтгэл бичжээ. Энэ бол захидлын агуулгыг эх бичгээс нь харж анх удаа Монголд дэлгэн тавьсан явдал байсан агаад тэрээр, “Монголын феодалуудад бошгийг халах аливаа суртал ерөөсөө таалагдахгүй байсан нь энэ захидлаас мэдэгдэж байна. Тэрхүү бичгийн дотор сүүлийн арав гаруй жилийн турш дахь Монгол орны улс төрийн түүхэнд холбогдох зарим зарим үйл явдлыг цэвэр феодалын үзлээр дүгнэн бичсэн байна”³⁰ гэж уг захидал нь нийгмийн тодорхой хэсгийнхны үзэл санааг илтгэсэн гэдгийг цохон тэмдэглэжээ.

Ийнхүү хүний итгэл үнэмшлийг хүндэтгэн үзэогүй, язгуур угсаа гарвалаар нь гадуурхан хавчдаг, оюун санааны олон ургальч үзлийг үгүйсгэдэг, бүх ард түмнийг сэтгэлгээний хоосролд оруулж гагцхүү социалист, коммунист үзэл санааг тулган, хүчээр хүлээн зөвшөөрүүлж байсан тэрхүү нийгэмд “Цэрэнпилийн хэрэг” гэгчийг өөр өнцөгөөс харах боломж үгүй байжээ. Гэвч Монголын ард түмэн үзэл суртлын хүлээснээс гарч эхэлсэн (1989-1990 он) тэр үес эл хэргийг өөр нүдээр

²⁸ ТЕГ. Тусгай Архив. Ф-1. “Цэрэнпилийн хэргийн хуулбар”

²⁹ Dilav Khutagt. *HOLOGRAPH MONGOL MANUSKRIFT OF THE POLITICAL MEMOIRS*. Asiatische Forschungen. Band 74. 1982. pp58. Otto Harrassowitz. Wiesbaden

³⁰ 1911 онд Чин улсаас салан тусгаарласнаас хойших үеийн хэлж байна-Ж.У.

харах, үзэх хандлага гарсан байна.

Анх 1990-ээд онд судлаач С. Баттогтох ХХ зууны эхэн үеийн Монгол улсын тагнуулын байгууллагын үйл ажиллагааны тухай бичсэн “Нууц хуйвалдаанаас нугалаа завхралд” номондоо “Цэрэнпилийн хэрэг” хэмээн нэрлэгдсэн хэрэг нь улс төрийн зорилготой зохион байгуулагдсан хэрэг байсан. Үүнийг тэр үеийн нам төрийн удирдлагад байсан хүмүүсийн хоорондын зөрчилт байдлын улмаас үүссэн нөхцөл байдлыг өөрт ашигтай байдлаар эргүүлэхийн³¹ тулд хийгдсэн зүйл гэдгийг баримтууд нотолж байна гээд өөрийн таамаглалыг дэвшүүлжээ³². Тэрээр энэхүү бүтээлээ Тагнуулын ерөнхий газрын Архивын баримтуудыг өргөн ашиглан бичжээ.

Түүхч О.Батсайхан 2005 онд Японы Гадаад хэргийн яамны Архивд суун ажиллаж байхдаа Цэрэнпил гүнгийн бичгийг хуулбарлан авч улмаар Цэрэнпил гүнгийн хэрэг явдлыг мөшгин судалж, бэсрэгхэн ном хэвлүүлэн гаргасан байна. Гадаад, дотоодын Архивд хадгалагдаж буй баримтуудыг ашиглан судалгааны эргэлтэнд оруулж Японоос тусламж гуйх гэсэн эл удаагийн хэргийн талаар нэлээд цэгтэй мэдээлэлийг өргөн олон түмэнд өгөхийн зэрэгцээгээр тэрбээр,

“Цэрэнпил гүнгийн бичиг нь тухайн үеийн Монголын түүхэн үйл явдлуудыг дүгнэхэд тус болохуйц мэдээлэл өгөхөөс гадна эдүүгээгийн өндөрлөгөөс үзвэл ...олон хүнийг хэлмэгдүүлсэн хэрэг болсон хэмээхийг илтгэн харуулж буй гэж үзүүштэй санагдмой. Цэрэнпил гүнгийн бичиг бол тухайн үеийн монголчуудын сэтгэлгээг ил тод харуулсан, Монголд өөрөөр сэтгэгчид олон байсныг харуулсан баримт яах аргагүй мөн”³³

гээд цааш нь судалгааны ажлын дүнд хүрсэн дүгнэлт нь: “Чухамдаа Японд хандан тусламж эрсэн эл бичгийг жирийн нэгэн хошууны бичээч санаачлан бичсэн хэмээн дүгнэхэд арай л гоомой мэт санагдмой... Энэ нь ийм их өндөр авч болох байсан уу гэдгийг улам нарийвчлан судлууштай мэт³⁴”, мөн “Цэрэнпил болон түүнтэй санаа нийлж, Японд хандан захиа бичсэн хүмүүс уг санааг анхлан гаргасан хүмүүсээ нууц байлгаж, өөрсдөө золигт гарсан болов уу хэмээх сэтгэл төрж байна³⁵” хэмээн үзсэнтэй бид санал нэг байна. О.Батсайхан хэргийн мөрийг мөшгөн гаргахыг зорьж тус номондоо олон сонирхолтой баримтуудыг оруулсан байна.

Монголын Дотоодыг хамгаалах газар хилийн чанад дахь Д.Цэрэнпилийн үл ажиллагааг тандан судлуулахаар Цэргийн бэлтгэлд ажилтай Н.Дугаржавыг цэргийн хэрэглэлийг хувьдаа завшсан хэргээр хоригдон шоронгоос орголоо гэсэн халхавчаар явуулахад Цэрэнпил нь хятад айлд амьдарч байгаад нас барсан,

³¹ Энд Сүхбаатарын эсрэг үйлдэлдээ Элбэгдорж Ринчино зохиосон хэрэг хэмээн үзжээ.

³² Баттогтох С. *Нууц хуйвалдаанаас нугалаа завхралд*. УБ., 1991, т.86-88

³³ Оохнойн Батсайхан. *Цэрэнпил гүнгийн хэргийн тухайд*. УБ., 2006, т.29

³⁴ Мөн тэнд, т.36

³⁵ Мөн тэнд

Цэвээнноров нь түүний оронд Японоос тусламж авах ажлаа үргэлжлүүлэн хийж байгаа хэмээн цуурхал тараан явж байсныг нь тогтоосон байна. Улмаар Цэвээнноровыг хилийн чанадад баривчлан устгах тагнуулын ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн³⁶ гэж Тагнуулын ерөнхий газрын түүх-альбом номонд тэмдэглэжээ.

Ийнхүү “Цэрэнпилийн хэрэг”-ийн талаар манай түүх бичлэгт 1923 оноос эхлэн ямар нэгэн хэмжээгээр хөндөгдөн бичигдэж ирсэн байх боловч энэхүү дуулиант хэрэгт хүргэсэн баримт бичгүүд чухам юу байв? Тэдгээрийг үйлдсэн нь цөөн хүний хүсэл зориг байв уу? Тус хэрэгт холбогдсон түшмэдүүд юуны учир эл хэргийг гардан хийв? Энэ нь Монголын нийгмийн янзбүрийн давхаргыг хүсэл эрмэлзлэл байв уу? Дээрх түшмэдүүдийн цаана нөлөө бүхий язгууртнууд байв уу? Гадаадад гарсан болон эл үед баригдаагүй бусад хүмүүс яасан бол? гэх мэт асуудалд хариу өгөхийг шаардсан олон зүйл байсаар байна. Аливаа улс төрийн захиалгат хэргийн гол эзний илрүүлэхэд бэрхтэй байдгийн нэгэн жишээ энэ болов уу.

2. Японоос тусламж хүсэх болсон нь

Миний бие 2014 онд Япон сангийн тэтгэлэг авч Токиогийн Гадаад Судлалын Их сургуульд зочин судлаачаар ажиллах завшаан олдосны ялдамд Японы Гадаад Хэргийн Яамны Архивын материалуудыг үзэх үеэр Цэрэнпилийн захидал хэмээн нэрлэгдсэн тэрхүү Өргөх бичиг болон түүнийг дагалдуулан илгээсэн бичигтэй танилцсан юм. Ингээд Японоос тусламж хүсэн илгээсэн захидалын агуулгын тухайд өгүүлсэн зүйл болон болон өргөх бичигт хавсарган илгээсэн баримтыг бүрэн эхээр нь хэвлүүлж, тайлбар зүүлт хийснээ толилуулъя.

Япон улсын эзэн хаанаас тусламж эрж илгээсэн эдгээр эх бичгүүд нь тэртээ 1920-иод оны үед Монголын нийгмийн нэгээхэн хэсгийнхны (тайж, лам, хэргэм зэрэгтэн, түшмэдүүд) үзэл санаа бодол, итгэл үнэмшлийг нь илтгэх толь болж, мөн тэр үеийн эрх баригч нарын бодлого болон Коминтерны зүгээс Дорно дахины ард түмнүүдэд хувьсгалт үзэл санааг тулган хүлээлгэх талаар ямар ажиллагаа хийсэн зэргийг ямар нэгэн будаг шунхгүй танин мэдэх боломжийг эдгээр баримтууд олгож байгаа тул тийнхүү анхаарлаа хандуулсан болно. Эдгээр баримт бичгүүдийг боловсруулхад нэлээд хугацаа орсон бололтой. Өргөх бичгийн ард хавсарган явуулсан бичиг бол 1921 оны 11 сард Зөвлөлт Орос улсад хуралдсан Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар хурал³⁷ дээр Коминтерны Гүйцэтгэх Хорооны дарга Зиновьев залуучуудын төлөөлөгчдөд хандан хэлсэн үг юм. Энэ нь орос хэл дээр тавигдсан илтгэл. Тиймээс түүнийг тэр үед монгол хэлнээ орчуулсан байна.

³⁶ “Тагнуулын ерөнхий газар 1922-2012” УБ. 2012, т.29

³⁷ Тус хуралд Монгол ардын намын төлөөлөгчөөр Данзан, залуучуудын төлөөлөгчөөр С.Буяннэмэх, хөдөлмөрчдийн төлөөлөгчдөөр Даваажав тэргүүтэй хүмүүс оролцсон. Илтгэлийг орос эхтэй нь тулган үзэхэд сайн орчуулга болжээ. “Первый съезд революционных организации Дальнего Востока” Изд. Исполкома Коминтерна, 1922-360 стр.

Япон улсын эзэн хаантанаа хандаж тусламж гуйх бичгийг боловсруулан бичих ажил 1922 оны 5 сарын үеэс³⁸ хийгдэж эхэлсэн ба Өргөх бичигт 1922 оны 9 сарын 16-нд тамга дарж, гарын үсэг³⁹ зурж бэлэн болгосон байна. Захидлыг хүргэхээр явсан Цэрэнпилийн тухайд өгүүлвээс, 1922 оны 11 сарын 30-нд Харбин хотноо сууж байсан Японы консулаас Гадаад хэргийн сайддаа Гадаад Монголын төлөөлөгч гэсэн Цэрэнпил тэргүүтэй 3 хүн⁴⁰ Монголын Жэвзүндамба хутагтын илгээсэн элч гээд ирлээ гэсэн мэдээ⁴¹, мөн түүнчлэн тэд 1923 оны эхээр Харбин хотод байсан тухай⁴² мэдээлж байсан байна. Харбин дахь Японы консулын газарт Монголын төлөөлөгч гэх тэр гурван хүний нэг нь хятад хэлтэй хүн байсан. Консулын газар тэдгээр монгол хүмүүст жуулчлалын визолгож болох эсэхийг Гадаад яамнаасаа лавлан асуусан байх бөгөөд Гадаад хэргийн сайд Учида өөрийн гарын үсэгтэй хариу цахилгааныг 1922 оны 12 сарын 6-нд Харбин руу илгээж, түүндээ Монголын төлөөлөгчдийн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэж өгч чадахгүй. Учир нь энэ нь зөвхөн Монголын асуудал биш, энэ нь Япон-Хятадын харилцааны асуудалтай нэн холбогдох учир тэдгээр хүмүүст Японд нэвтрэх виза олгохгүй байх нь зүйтэй гэсэн хариу өгчээ. Харбины консулаас 1923 оны 1 сарын 23-ны өдөр Токио руу сайддаа илгээсэн цахилгаандаа Цэрэнпил болон тэдгээр хүмүүст Японоос тусламж эрэхээр явах ажилаасаа татгалзахыг зөвлөлөө. Гэвч тэд хэд хоногийн дараа дахин Консулын газарт ирж “бид Жавзандамба хутагт хааны албан бичгийг авч явна. Тиймээс үүнийгээ Японы засгийн газарт албан ёсоор өгөхийг хүсч байна. Бид эл бичигийг хятад хэлрүү орчуулаад, дахиад ирнэ гээд явсан. Тяньжин явсан гэсэн одоо сураггүй байна. Дахин энд ирээгүй” хэмээн мэдээлсэн байна.

Японы Гадаад хэргийн яамны Архивд хадгалагдаж буй өөр нэгэн баримтаас үзэхэд 1923 оны 6 сарын 21-нд Японы колони орон болох Солонгосын Сеул хотын Цагдаадын хэлтэсээс Гадаад хэргийн яамныхаа Азийн хэлтэст илгээсэн мэдээлэл болох “Гадаад Монголын лам ирж өнгөрсөн тухай” гэсэнд: “...нэр нь үл мэдэгдэх нэгэн лам хүн 7 сарын 7-нд Солонгос-Хятадын хил дээр байдаг Синийджухотын

³⁸ Urgunge Onon. *On document from Office of Diplomatic documents Japanese Foreign Ministry. pp71*; УТА Ф-284, д1, хн111. Дампилын өчигт Цэрэнпил түүнд Япон руу захидал бичих тухай хавар эхэлсэн гэжээ.

³⁹ *On document from Office of Diplomatic documents Japanese Foreign Ministry. 511332*

⁴⁰ Цэрэнпил, Цэвээнноров, Хачуудын хувилгаан нар хязгаар нэвтрэсэн гэж Дилав хутагт бичсэн. *The Dilav khutagt Memories and Autobiography of a Mongol Buddhist Reincarnation and Revolution* by Owen Lattimore and Fujiko Isono. Asiatische Forschungen .Band 74, 1992, 58. Otto Harrassowitz. Wiesbaden. Мөн Харбин дахь консул Монголын төлөөлөгч гэх 3 хүн ирсэн гэсэн байна. *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan*. Reference Code: B03050172200, 511299

⁴¹ *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan*. Reference Code: B03050172200, pp.511297-511299

⁴² *History of the Mongolian People's Republic* by William A. Brown; Urgunge Onon. C.R. Bawden *The China Quarterly. №71 (Sep., 1977) pp798*, Cambridge University Press - *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan*. Reference Code: B03050172200, pp.511309-511310

зочид буудалд ирээд төмөр замаар Хятад руу явсан, Сатогийн хамт явж байсан. Тэрээр чухал асуудад хэлэлцэхээр явж байна. Монголд улаантнууд даварч лам нарыг хэцүү байдалд орсон тухай ярьж байсан гэнэ” хэмээн мэдээлсэн байна.⁴³

Цэрэнпилийн тухайд дээр өгүүлсэн зүйл дээр тодруулан нэмэрлэхэд, тусламж эрсэн бичгийг Японы талд гардуулан өгсөнөөс хойших үед холбогдох хоёр баримт Японы Архивд хадгалагдаж байна. Тэдгээрээс үзэхэд 1924 оны 1 сарын 11 ба 12-ны өдөр тэмдэглэгдсэн хоёр хуудас баримтанд Мүгдэн дахь Японы консулаас Гадаад хэргийн сайддаа илгээсэн цахилгаанд “Монголын хутагтын төлөөлөгчийн тухай мэдээлэл” гэсэн гарчигтай мэдээнд Мүгдэнгээр дамжин явах гэсэн Цэрэнпил замын бэлтгэлээ базаахаар Бээжин явсан, нэг жилийн дараа тэр амьд байсан гэж мэдээлсэн бол 1 сарын 12-ны цахилгаан мэдээнд Квантуны мужийн дарга Кодама Хидэогоос Гадаад яамны сайд Мацуид: “Гадаад Монголын төлөөлөгч ирсэн тухай” гэсэнд, 1924 оны 1 сарын 8-нд Гадаад Монголын хутагтын 2 төлөөлөгч Квантун мужийн дарга дээр ирсэн. Цэрэнпил, Долгор нар мужийн даргын нарийн бичигтэй уулзсан гээд, жич: тэдний ярьсан зүйл хэмээн 3 хуудас зүйлийг хавсаргажээ. Тэд ярихдаа,

“1922 оны 8 сард Нийслэл Хүрэнээс нийт 17 хүн замд гарсан. Есөн хүн замдаа улаантнуудад алагдсан. Бидэнд тус хүргэсэн нэгэн хүн Хутагтын засгийн газрын тамгатай бичгийг Японы Гадаад яамны сайдад өргөн барьсан. Японы тал доторхой хариу өгөөгүй учраас Квантуны мужийн даргад бараалхаж өөрийн орны байдал нөхцөлийн талаар тодорхой тайлбарлыа гэсэн ажгуу. Бид Японоос тусламж авхыг хүсч байна. Улаантан нар Монголыг дарангуйлж байна. Ялангуяа лам нарыг хавчин хяхаж байна. Их Хүрээний хүн ам 13 түм, 1000 улаан орос байна. Түүнээс гадна монголчуудын дотор улааны нөлөөнд орсон 1000 хүн байна”

гээд Квантуны мужийн даргатай уулзах хүсэлтэй байгаагаа илэрхийлэхэд, нарийн бичгийн дарга монголчуудын байдлыг ойлголоо. Бид дипломат ажилд оролцох эрхгүй, гэхдээ мужийн даргадаа мэдэгдье гэж бичсэн баримтыг⁴⁴ үндэслэвэл, 1924 оны 1 сард Цэрэнпил Квантун мужид байсан бөгөөд тэрээр Мүгдэн, Квантун, Бээжингээр явж Японоос тусламж дэмжлэг олох гэсэн ажиллагаагаа хийсээр явж байжээ. Эл үед эх газрын Ази дээр Японы хамгийн том төлөөлөгчийн газар Квантун мужид байсан аж.

Ингээд хэн нь үл мэдэгдэх, Монголын төлөөлөгч нарын нэгэн төлөөлөл болсон хүн Токио хотноо хүрэлцэн очиж Гадаад хэргийн яамнаа захидлыг

⁴³ *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan*. Reference Code: B03050172400, pp.511425

⁴⁴ *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan*. Reference Code: B03050172400, pp. 511427-511430

гардуулан өгчээ. Японы эзэн хаантанаа илгээсэн Өргөх бичиг болон дагалдсан бичгийг 1923 оны 5 сарын 19-нд Японы Гадаад хэргийн яам хүлээн авсан байх бөгөөд 2 сарын дараа тус захидалд өгсөн хариуг тэмдэглэсэн бичгийн хамт эх баримтуудыг Японы он тооллын Тайсё 12 (1923) оны⁴⁵ 7 сарын 19-нд Гадаад яамны бичиг хэрэг дээр тэмдэглэн авчээ.⁴⁶

3. Өргөх бичиг⁴⁷

Японы эзэн хаанд өргөхөөр бичсэн нугалбар бичгүүд нь тухайн үеийн Монголын нийгмийн сэтгэл зүйг илтгэж байхын сацуу тэрхүү 1920-оод оны үед өрнөж байсан хэрэгт явдлуудыг бид өнөөдрийн өндөрлөгөөс шүүн бичих биш харин тэрхүү түүхэн үйл явдлын амьдгэрч нар өрнөж буй хэрэг явдлыг хэрхэн үзэж хүлээн авч байсныг эх бичиг дээр тулгуурлан гаргаж ирэх нь үнэн бодит дүр зураглалыг буй болгож чадна хэмээн үзэж байна. Япон улсын Гадаад хэргийн яаманд хадгалагдаж буй Японоос тусламж хүссэн бичиг болон түүнд хавсарган илгээсэн баримт зэрэг нь “Ар Монголын амьд Буддагийн элч нарын ирүүлсэн бичиг” гэсэн гарчигтай хадгалагдаж байна.

Ингээд захидлыг шинжлэх үзэхэд, Захидлын эхний нүүрэнд “Өргөн дэвшүүлэх нугалбар” хэмээн Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тамганы дардас дээр бичсэн байна. Тамганы өнгө улаан хүрэн бөгөөд захидлын бүх хуудас дээр тус яамны тамга дарсан байх бөгөөд тамгыг баталгаажуулсан зурвасыг мөн хар өнгийн бэхтэй бийрээр зуржээ⁴⁸.

Өргөх бичигт дарсан тамганы талаар Онон Өргөнгөө⁴⁹ “Дилав хутагт 1949 онд бичсэн “Ар Монголын улс төрийн дурьдатгал” өгүүллийг хэвлүүлэхдээ оршил болгон бичсэн хэсэгтээ:

⁴⁵ Эзэн хаан Тайсё Ёсихито 1912-1926 он. Япончууд эзэн хааны хаанчлалын жилээр он тооллоо тэмдэглэдэг уламжлалтай.

⁴⁶ *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan*. The documents brought by the representative of the Living Buddha in Outer Mongolia. Reference Code: B03050172300, pp.511329-511330

⁴⁷ The documents brought by the representative of the Living Buddha in Outer Mongolia. *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs. Records of the Ministry of Foreign Affairs, Series 1: Politics. Category 6: Domestic Administration of Various Countries, Section 1: Asia. Miscellaneous articles concerning the internal political situations of various countries./China/Moko (Mongolia) Volume 5.*

Баримтууд 511329-511383-р хуудсанд байх бөгөөд үүний 511329-511330-р нүүр Японы ГХЯ-ны тайлбар бичиг, 51131-р тал Захидлын дугуйны зураг, 51132-51141-р тал нь захидал, т.51142-511383 дагалдуулсан баримт байх бөгөөд дугуйны бичиг японоор, захидал нь хичээнгүй монгол бичгээр, дагалдуулсан баримт гүйлгэн бичгээр муутуу, улаан шугамтай цаасан дээр хар өнгийн бэхээр бичсэн, нийтдээ 60,5 нугалбар байна.

⁴⁸ Монгол албан бичгийн уламжлалд Тамганы дардасыг үнэн бодит болохыг баталгаажуулан дээр нь зураас –зураасан тэмдэг зурдаг уламжлал буйг энд хэрэглэжээ. Өөрөөр хэлбэл эл бичиг дээр дарагдсан тамга үнэн болохыг батлан үүнийг хянах эрх бүхий хүнээс хийдэг тэмдэглэл юм.

⁴⁹ Онон Өргөнгө өмнө дурьдсан өгүүллийн эхэнд тэрээр эл захидлыг анх илрүүлсэн хүн болж байна гэдгээ онцлон тэмдэглэжээ. Мөн тэрээр эл захидал нь Дилав хутагтын бичсэн дурсамж номонд өгүүлсэн \ эш татан бичсэн Ж.У.\ зүйлийг тодруулхад нэгэн шижим болж байна хэмээн уг олдворынхоо үнэ цэнийг тодорхойлжээ. Улмаар монгол захидлыг уншиж ойлгоход дөхөм болгох үүднээс 7 зүйлд товч тайлбар хийсэн оршил хэсэг бичсэн амой.

“...Японоос тусламж эрсэн бичигт Манзушир хутагт тамгаа дарсан гэж бичсэн байдаг боловч энэхүү захидлаас үзэхэд Дотоод яамны тамга байна. Тамганы бичээс улаан өнгөөр байгаа учраас бичээс нь уншигдахгүй хэцүү байсан боловч би тайлан уншлаа. Энэхүү бичиг бол үнэн магад юм байна. Учир нь ийм өргөх бичгийг бичиж, хуурамч тамга дархыг зүрхлэх хүн тэр үед байгаагүй болов уу? хэмээн өөрийн санааг бичжээ. Мөн тэрээр цааш нь: Жалханз хутаг Баруун хязгаар руу томилогдоход Ерөнхий сайдын тушаалыг Манзшур хутагт хүлээх болсон гэж Дилав хутагт бичсэнийг эш татаа, цааш нь Дотоод яамны тамга 1922 оны 9 сарын 16-ны үед түүнд байсан байж болох бөгөөд тиймээс Манзшур уг тамгыг дарж өгсөн байх талтай”⁵⁰

хэмээн бичсэн нь ялимгүй ташаарсан дүгнэлт болжээ. Учир нь эл үед Манзшур хутагт Цэрэндорж тамга хамаарах боломжгүй байсан.

1923 оны хавар Цэрэнпилийн хэргийн талаар Засгийн газраас томилогдсон тусгай комисст Шүүх явдлын яамны өргөсөн бичигт дурьдсанаар, Цэрэнпилийн хэрэгт холбогдсон Сэцэн хан аймгийн Дампил, Луузан, Чадраабал нар:

“Японоос тусламж эрсэн бичигт дарах хуурамч тамгыг лам Лувсанмижидээр сийлүүлсэн хэмээн мэдүүлсэн ба ялд унасан Лувсанжимид ч өөрөө, өчүүхэн би гагцхүү дүү Луузангийн үгийг дагалдаж тамга сийлсэн нь туйлын үнэн”

гэж мэдүүлсэн байна. Ийнхүү хэрэгт холбогдон ялтан нэр зүүсэн хүмүүс хуурамч тамга үйлдсэн хэмээн мэдэгдэжээ.

Тамганы тухай асуудлыг цааш мөшгөн хөөвөөс, Их шавийн томоохон нөлөө бүхий Манзшур хутагт Цэрэндорж эл хэрэгт болон бусад хэрэгт холбогдуулан 3 удаа⁵¹ байцаасан байх бөгөөд тэрээр,

“Ардын засаг байгуулагдаж миний эрх мэдлийг хасаж тамгыг хураах буюу шавь ардуудыг шуудулсын мэдэлд шилжүүлэх болсон зэрэг учраас миний эрх мэдэл ба алдар нэр нь буурч эрх ашгаа алдах болж Ардын засгийг шууд эсэргүүцэх замдорж удаа дараа орж...”⁵²

байснаа шударгаар мэдүүлсэн, өөрийн үзэл бодол итгэл үнэмшилдээ үнэнч нэгэн байсан юм. 1928 онд засгийн эрхэнд гарч ирсэн зүүнтэнүүд Коминтерны гар хөл болон тус оронд алага хядлагаа хийж эхэлсэн үе буюу 1930 оны 7 сарын 23-ны өдрийн мэдүүлэгтээ тэрбээр,

⁵⁰ Inner Asia. Vol.1, Number 1, 1996. Mongolian and Inner Asia Studies Unit. University of Cambridge, pp72

⁵¹ 1923, 1930, 1937 онд тус тус болно

⁵² Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив. Ц-1603

“Ардын засгийн үед засаг төрийг устгахаар гадаад дор оргон явсан Цэрэнпил нарын хэрэгт холбогдож байцагдаж явсан бөгөөд хэрхэн холбогдсоноо тодорхойлбоос, Анх тэрхүү Цэрэнпил гэгч манай гэрт очиж наддор нэгэн бичиг уншиж үзүүлэн тийнхүү Япон улсаас тусламж гуйж одох тухай хийвээс ямар болох талаар зөвлөн хэлэлцэх дор би зөвшөөрч өөрийн саналыг илэрхийлэн хэлж байсан. Үүний дараа жинхэнэ авч явах бичгийг ёсчилон үйлдэж авчиргаад сонсгосныг зөвшөөрч байсан. Гэтэл тамгаа дарж өгнө үү хэмээсэн дор уул бичгийг үзвээс хэд хэдэн тамга дарсан мэт харагдсан бөгөөд тэдгээр тамгуудыг Богд хааны ба Дотоод Яамны сайдын тамга хэмээж байсан билээ. Энэ зүйлд би заавал тамга дарах хэмээх явдал үгүй. Нэгэнт Богд эзэн гэгээний тамга байна хэмээж тамгаа дарсан үгүй буцаасан болой. Хойно сонсвоос тэрхүү Цэрэнпил оргож явсан хэмээн сонсогдсон”⁵³

гэсэн гэж мэдүүлсэн дотор, ... уул бичгийг үзвээс хэд хэдэн тамга дарсан мэт харагдсан бөгөөд тэдгээр тамгуудыг Богд хааны ба Дотоод Яамны сайдын тамга хэмээж байсан билээ” гэснээс үзэхэд тэрбээр хуурамч тамга болон батламж тавигдсан байгааг мэдсэн бөгөөд үүнийг Ардын засгийнханд илчлэхийг хүсээгүй байна. Японд явуулсан захидлаас үзэхэд тэрбээр гагцхүү алдар нэрээ бичин гарын үсгээ зурж өгсөн байна. Манзушир хутагт Богд хааны тамга байсан гэж мэдүүлсэн боловч Өргөх бичиг дээр хааны тамга эсвэл мутрын тэмдэг алга байна.

Манзушир хутагт Цэрэндорж нь 1921 оны 2 сард сэргээн босгогдсон шинэ засгийн газарт Ерөнхий сайдын албыг 1921 оны 2 сараас 7 сар хүртэл богино боловч хугацаанд хашиж байсан агаад өөрийн барьж байсан тамгаа Ардын засагт хүлээлгэн өгсөн нэгэн байсан учир Дотоод яамны тамгыг маш сайн мэдэх бөгөөд албан бичиг болон тамгыг хэрхэн баталгаажуулдагийг сайн мэдэх хүн байсан амуу.⁵⁴ Нөгөө талаар тамга бодит байсан ч байж болох мэт. Учир нь Японоос тусламж гуйх санаа нилээд эрт буй болсон ба эрх бүхий хүмүүс оролцсон байх талтай бөгөөдэл хэргийг удирдан зохион байгуулхад бас тодорхой цаг хугацаа орсон болов уу хэмээн бодогдоно. Мөн нөгөө талаар хэрэгт холбогдон нь илчлэгдсэн хүмүүс бүх хэргийг өөрсдөө даан гарсан байх ч талтай болов уу. Өргөх бичигт, “Олноо өргөгдсөний 12 он усан нохой жилийн намрын тэргүүн сарын 25-ны өдөр. Монголын аймаг савыг баригч Ачит номун донхор Манзушир хутагт батлан үсэг зурав” хэмээсэн тухайд, Манзушир хутагт Цэрэндорж Дотоодыг хамгаалах газарт удаа дараа мэдүүлэг өгөхдөө үүний талаар огт дурьдаагүй, энэ үйлдлээ нуун дарагдуулсан байна. Тэрээр мөн хойтон жил нь

“Гэтэл өнгөрсөн 13 онд тус хотноо орос хэмээх Гомбын бие миний гэрт очиж Япон улсыг түшиглэн түүний тусламжаар Хувьсгалт Ардын

⁵³ Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив Ц-1595

⁵⁴ ТЕГТ Архив Ц-1595

Засгийг устгах тухай бодлого бүхий болохоо над дор товчоор хэлмэгц миний бие уг хэрэгт хүчин туслах түүний ажлыг бүтээлгэх явдалд тус болохыг түүнд хэлж байсан. Гэтэл түүний бие дахин надтай уулзаагүй бөгөөд тэр үед ДХГ-т баригдаж буудан алах ял авч дууссан⁵⁵”

гэж мэдүүлсэн байна. Эдгээр баримтаас үзэхэд Ардын засгийн эсрэг тууштай зогсож, гаднаас тусламж дэмжлэг авч хуучин байгууллаа тогтоохыг хүсэгчдийн нэг нь Манзушир хутагт Цэрэндорж байжээ.

Өргөх бичигт, өргөн нь 72 мм, өндөр нь 111 мм хэмжээтэй цагаан цаасан дээр хийсэн

“Халх Монгол улсын төлөөлөгч түшмэл

Нэр Лувсанцэрэн

Нийслэл Хүрэннээ суумой”

гэсэн бичигтэй нэрийн хуудас байна. Энэ хүн хэн байсныг өнөө хүртэл бид тогтоож чадаагүй байгаа билээ.⁵⁶ Лувсанцэрэн гэгчийн тухайд Онон Өргөнгө бээр, “Лувсанцэрэн бол өндөр албан тушаалын түшмэл бөгөөд тэрээр эл захидлыг Японд хүргэж өгөх ёстой байтал өөрөө явсангүй, харин түүний оронд Цэрэнпил явсан⁵⁷” хэмээн тайлбарлажээ.

4. Өргөх бичгийн агуулга

Бичигт Япон улсын эзэн хаантанаа хандан:

“Их Рибэн улсын эзэн хааны амгалан жаргалангийн наран тунамал, гурван цагийн бурхан лугаа ялгалгүй зарлигийн эрих баялаг, насан хийгээд бие сэтгэл хэмжээлшгүй, хэтэрхий амгалан төгөлдөр гэгээхэн таны алтан өлмий доор мөргөн сөгдөж өргөвөө.

Рибэн улсын хааны гэгээхэн бие болвоос маш ариун бөгөөд халдаж үл болох их улсын тэргүүн мөн болох, улсын бүх дээд эрхүүдийг биедээ товчилж, Үндсэн хуулийн үзлээр эрхүүдийг хэрэглэдэг Их хаан танаас тусламж гуйн одсугай. Энэрэнгүй өршөөлт эрдэм билиг хүчин эрдэнэ олбороор төгсөн алтан гэгээхнээр эл хэргийн байдал учрыг байцаан толилж, өчүүхэн монголчуудыг огторгуйн наран хол боловч замбуутивийг гэрлээр гийгүүлдэг адил илбэн тэнхэрүүлэх ажаамуу”⁵⁸

хэмээн дээдлэн хүндэлж буйгаагаа илэрхийлэхийн хамт Эзэн хааны эрх хэмжээг

⁵⁵ ТЕГТАрхив Ц-1603

⁵⁶ Архивын баримтуудыг үзэж байхад эл үед Нийслэл Хүрэнд гадаадын иргэдийн асуудал хариуцсан төлөөлөгч Лувсанцэрэн гэх хүний нэр гардаг. Гэвч энэ хүн эл хэрэгт холбогдсон гэсэн баримт үгүй мэт

⁵⁷ Urgunge Onon. *On document from Office of Diplomatic documents Japanese Foreign Ministry*. INNER ASIA. Occasional Papers. Volume 1, Number 1, 1996, pp.71

⁵⁸ *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan* Code: B03050172300. Subseries Key B-1-6-1-142. pp.51132-51142

онцлон дурьдсан нь тэр үеийн сэхээтнүүд эл улсын талаар зэгсхэн мэдлэгтэй байсанг илэрхийлнэ. Ер нь ХХ зууны эхэн үеийн Монголд олон улсын эрх зүйн талаар чамгүй боловсролтой хүмүүс байсныг түүх гэрчилгээ болно. Монгол улсын засаг төрийн байдал хэрхэн уламжилж ирсэн тухайд, “Дундад Иргэн улс эзэнт засгийн эрхийг шилжүүлэн бошго журмыг халаадгэмин нам болсон, шинэ засгийн гашуун хорсолтой цаазыг эс даган тусгаар улс болж” гэсэн нь Хятадад Чингийн төрийг түлхэн унагаах нам бий болж эзэнт гүрнийг түлхэн унагаах тэрхүү үйл явдал өрнөх үед манай Монгол Шинэ засгийн бодлого хэмээн гашуун хорсолтой цаазыг эс даган тусгаар улсаа байгуулсан. Гэтэл 10-аад жилийн дараа:

“манай засгийн газрын эрх барилцаж сайд хэмээгдсэн харгис хэдэн ноёд Бээжин хотноо одож шарын шашин хийгээд Хаан эзэн Очирдараа Богд багш лам юугаан умдгайлан огорч гэмин намын шинэ засгийн муу суртал дор дахин аялдан дагалдаж, үлэмжхэн тооны цэргийг урин авчирч суулгаад Халх даяарт хохирол гашууныг эдлүүлэн тэсхүйе бэрх зовлонгийн туйл болгож”

гэж бичсэнээс үзэхэд, автономит засгийг унагаах хэргийг монголчууд өөрсдөө сэдсэн гэсэн байна. Үргэлжлүүлэн,

“Оросын цагаан намын их цэргийг урин авчирж сагуулган, Халх даяарт хоосрол хашигууныг эдлүүлэн тэсхүйе бэрх зовлонгийн туйл болж бүхий дор тэр сацуу Оросын цагаан намын их түшмэл Барон хүчирхэг цэргийн хамтадаан тусламжаар Богд лам болон Халх монголчуудыг өмгөөлөн хамгаалхаар манай Нийслэл Хүрээнээ нэвтрэн ирээд. Тэдгээр харгис гэмин лугаа байлдан даран сөнөөгөөд, түр зур төвшитгөн тохинуулж”

гэж бичсэнээс үзэхэд цагаантнуудыг урин оруулж ирсэн ба тэдний хүчээр гаминг Нийслэл Хүрээнээс хөөн гаргажээ. Улмаар,

“...төвшитгөн тохинуулж, тэнхэрүүлхийг шамдаж ахуй дор мөн аанай манай монголын харгис хэдэн хүмүүс умараа этгээд дор агсран бүхий улаан намын оросууд⁵⁹ лугаа хуйвалдаж, цэрэг ардын хамт цөмрөн ирж тусын өршөөлт Барон түшмэл цэргүүд лугаа хямралдан байлдаж, Барон түшмэлийн цэргүүд бага дийлэгдэн зугтан гарсан дагалдаагаар эдний улаан намын цэргүүд хүчин сүрээр журамт засгийн гол цаазыг эвдэн, Ард намын засаг хэмээх үзлээр журамламой, дагуулмой хэмээн эзэрхэнбидний монголчуудыг толгой дараалан захираад өдийхэн үеэс болов”

⁵⁹ Орос оронд Октябрийн төрийн эргэлт гарч засгийн эрхийг улаантнууд булаан авч, хөрөнгө тэгшитгэх нийгэм байгуулна хэмээн цуст харгислал хийж эхлэсэн тэр үед монголчууд түүнээс ихэд болгомжилж байсан юм. Улсын Дээд, Доод хурал (1914-1919) улааны аюулаас хэрхэн сэргэмжлэх талаар удаа дараа хэлэлцэж байсан бөгөөд эцэст нь Дээд хурлын шийдвэрээр Хятадад хандаж автономит засгаа устгуулсан гунигт явдал гарч байсан билээ. Үүнд гэмшиж байсан хүн олон байсан. Тиймээс ч тэд төдөлгүй нэгдэн АНУ болон Японоос тусламж гуйх ажлыг сэдэж байсан амуу.

гэж Барон Унгерныг хөөн гаргаад улаан намын туслалцаатайгаар Ардын намын засаг эзэрхсэнд илт дургуй байгаагаа илтгэжээ. Мөн үүнээс өмнө өөрсдийгөө,

“бидний монгол овогтон бол язгуураас бурханы аврал нигүүлсэл дээр амьдран хүмүүжиж, ёслол номыг журамлаж өчнөөн төчнөөн жил болтол Очирдара богдбагш лам юугаан орой дээрээ барин зүрхнээс хагацалгүй шүтэж тахисаар өмсөх үдэх уух алин хүсэлтэй нийтээр шагнасан нутаг дор итгэж аж төрсөн ану”

гэж сэтгэл хангалуун амьдарч байсан гэжээ. Түүний дараа Монгол оронд юу өрнөөд байгааг,

“Үнэн санааттөв шулуун түшмэл ардхүн олонхийг баривчлан хорьж алаад, бурхан шашны шүтлэг хийгээд дээшдээ Очирдара Богд багш ламын зарлиг таалалыг огтхон ч ойшоохгүй шууд таслан зөрчиж, басхүү олон хутагт хувилгаадын хурал номын их суртал журмуудыг хасан хомстгож, бас олон ван гүнгийн хэргэмтэн угсаатанг бууруулхыг завдана”

гэжээ. Ардын засаг тогтсоны дараа Зөвлөлт Оросын большевик нам, Коминтерны төлөөлөгчид тус орны улс төр-нийгмийн амьдралд улайм цайм оролцож эхэлсэн бөгөөд өөрсдийн бодлогыг тулган хүлээлгэж байсан. Энэ явдалд дургүйцсэн болон Монголыг Монголоор нь байлгах гэсэн хэнийг боловч хэлмэгдүүлэн замаасаа зайлуулж байсан билээ. Энэ үед Ерөнхий сайд Д. Бодоог үгүй хийсэн (1922.8.30), Д. Чагдаржавыг 1922 оны 8 сард эх орноосоо урвасан хэмээн ял тулгаж, улмаар цаазаар авачив, Дамбийжанцанг сөнөөх, Егүзэр хутагтын хуйвалдаан Саж ламын хэрэг гэгчээр олон хүнийг хомроглон баривчилж ялласан хэрэг гарчээ. Нэгэнт улаан намын сурталд автагдсан Ардын намынхан засгийн эрхийг барьж эхэлсэн анхны өдрөөсөө эхлэн шашины эсрэг олон арга хэмжээ хэрэгжүүлж эхэлсэн юм.

Анх Их шавийн онцгой эрх дарханд халдаж, түүний ашиг орлогоос Улсын санд хураах, улмаар жас жавийн хөрөнгөнөөс 100%-иас 25% татвар авах, лам ноёдыг улаа хэрэглэхийг хориглох, зарим хурал номыг зогсоох зэрэг ажиллагаа явуулж байсан нь нийгмийн тодорхой бүлгийнхны дургүйцэлийг төрүүлж байв. Мөн удахгүй ихэс дээдсийн хэргэм зэргийг хүчингүй болгож, нутаг захирах эрхийг хасах гэж байгааг мэдсэн учир Ардын засгийн бодлогын эсрэг үзэлтнүүд үлэмж олон болоход хүргэж байжээ. Тиймээс тэд,

“Доошдоо олон түмний онц гаслангаар нэрвэгдүүлсэн зэрэг хүндтэй дарлагдлаас яахан хагацах аргыг олноор дахин эвдэн санал гаргаж нууц зөвлөлдөөд, улс бүгдийн төлөөнөөс бичиг цэргийн түшмэл Цэрэнпил, Лувсанцэрэнгээр нууцаар авхуулан одуулж, Халх Монгол улсын угсаа бүхий олон хан, ван, гүнгүүд бас олон хутагт, шанзудба лам хичээнгүйлэн үнэмлэх тамга дарсан нугалбар бичиж”

өргөн дэвшүүлжээ. Тэгээд юу хүсэв хэмээвээс,

“Дээрээс толилон тогтоож, улаан намын тэнэмэл болсон харгис засгийг битүүгээр номхруулж, Халх монголчуудыг сулхан болгож хүчнийг зузаатгатугай хэмээн хүссэн,
- амирлангуй, нигүүлсэнгүй буян чуулганаар авран өршөөж, улсын засагт гутамшиг үгүй болгож, сонсголонгийн алдрыг арван зүгт дэлгэрүүлэн, гайхамшигт эрдмийн гавьяа хүчнийг нэн илэрхийлүүлэх хүнд хишиг хүртэхийг хүсэн гуйж,
- цагийн бэрхэд гадаад, дотоодын харгис тэрслүүгийн тархинд хүндтэй тархидуулсан Халх монголчуудыг харангуй зовлонгийн бүрхэгээс түргэнээ хагацуулах их түшмэл цэргийн чуулганыг хурдахаар довтолгон өршөөн илгээгээд,
- тэрс буруу үзлээр эзэрхэн газар орныг эзлэн түйвээсэн улаан нам тэдэн лугаа урван нийлсэн монгол харгис хүмүүсүүдийг хамтаар гэтлэн сөнөөж,
- Очирдара Богд багш Жэвзүндамба ламыг мину юугаан хуучин хэвээр улсын эзэнд өргөмжлүүлэн, шашин төр хоёрын хэргийг хослон баруулж тахиглан, монголчуудын явуураа ирсэн хэв хуулийг хэвээр хэрэглүүлэн, уг үндсэн нь нутгийн хамтад нийтдээ өршөөн”

барихыг хүсч байгаагаа илэрхийлээд, үүний тулд цэрэг түшмэл илгээнэ үү хэмээн наминчлан гуйжээ. “Монгол нэгэн өчүүхэн бөлгөө” тиймээс “Гэгээн соёлоор удирдан хамгаалах хүнд хишиг хүртэхийг түмэнтээ хүснэ” гэж Япон улсын ивээл доор орох хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Эцэст нь,

“Их Рибэн улсын эзэн хаан гэгээнтэн таны алтан өлмий дор нугалбар өргөн дэвшүүлээд, басхүү Ард нам хэмээгчдийн санаа зорилт, эзэнт хөрөнгөтөн хүчирхэг хэдэн их улсыг эзлэн бууруулхыг хичээж хуралдсан⁶⁰ хүмүүсүүдийн санал зөвлөлийн бичгийн хуулбаруудыг тусгай сийрүүлж хамтаар байцаан толилуулхуйд бэлтгэж, нэгэн дугуй дор агуулан”

илгээснээ бичжээ. Дугуйны нүүрэн дээр японоор, “Тайсёгийн 12 оны 5-р сарын 19-ний өдөр. Ар Монголын Жавзандамба хутагтын төлөөлөгч авчирсан баримт бичиг”, ар талд “Гадаад хэргийн яам. Ёшизава. Азийн хэргийн товчооны дарга”⁶¹ гэж бичсэн байна.

5. Японы хариу

Японы тал уг бичгүүдийг хүлээн аваад ямар хариу өгсөн тухай тус баримтын эхэнд хавсаргасан байна. Түүнийг сийрүүлвээс,

⁶⁰ 1921 оны 11 сард Эрхүүд хуралдаанаа эхлээд улмаар Москва руу хурадаанаа шилжүүлсэн Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хурлыг хэлж байна.

⁶¹ *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan* Code: B03050172300. Subseries Key B-1-6-1-142. pp.51129-51131

“Азийн хэргийн товчооны дарга Азийн хэргийн товчооны нэгдүгээр хэлтэс. Тайсегийн 12 оны 7 сарын 19-ний өдөр бүртгэгч хүлээн авав.

5 сарын 19-ний өдөр Ар Монголын Жавзандамба хутагтын төлөөлөгч гэгч хүн Үсүки Масүзоо, Катая Дэнзоо хоёрыг дагаж яамандирэв.

Азийн хэргийн товчооны даргатай уулзаж илгээсэн бичгийг гардуулж, эзэн хаанд айлтган өргөхийг хүсэв. Азийн хэргийн товчооны дарга ирсэн хүнд хэлсэн нь: гагцхүү Ар Монгол өөрийн ашиг тусыг бодож эзэн хаанд айлтгал өргөхийг хүсч байгаа явдлыг өнөөгийн олон улсын харилцааны нөхцөл төлөв байдлаас хамааран зохицуулахад хэцүү байна” гэсэн харну өгсөн.

Гэтэл тэр нөхөр бичиг дээр бичигдсэн бодит байдлыг дахин тайлбарлан ярьж, өнөөдөр даруйхан эзэн хаанд айлтгахаар арга хэмжээ авахад хэцүү байгаа бол дараа тохиромжтой үед уламжлан арга хэмжээ авч өгч тус болохыг үнэхээр хүсэж байгаагаа илтгэн хэлэв. Мөн тэрээр өнөөгийн нөхцөл байдалд Ар Монгол Японд найдахаас өөр арга зам үгүй байна. Улаан цэргийн дарамтаас болж мөхөлийн замд орж байгаа учир өөр сонголт алга байна хэмээн найдваргүй хүнд зовлон зүдгүүрийнхээ тухай гомдоллож, дахин дахин Японоос тусламж гуйж байгаагаа илэрхийлхийн дашрамд Ар Монголыг цаашид хэрхэх талаар товчооны даргаас зөвлөмж авах хүсэлтэй байгаагаа хэлэв.

Азийн хэргийн товчооны даргаас захидлыг нь Гадаад хэргийн сайдад гардуулж тусламж гуйсан учир шалтгааныг мэдэгдэсэн боловч одоохондоо үүнээс илүү яаж ч хандах боломжгүй гэдгээ тайлбарласан бөгөөд манай Япон Ар Монголын хүнд зовлон зүдгүүрт байдлын тухайд гүн эмгэнэл илэрхийлж байгаа боловч Япон зүгээс идэвхтэй тусламж үзүүлэх, эсхүл Хятадын засгийн газарт ямар нэг санамж зөвлөгөө өгөх мэт арга хэмжээ авах боломжгүй. Ар Монголыг Хятадын газар нутаг мөн гэдгийг үнэндээ эргэж харахад эсхүл Ар Монгол гагцхүү өөрийн ашиг тусаа бодох нь маш их ухаалаг бус арга мөн хэмээх учир шалтгааныг дэлгэрэнгүй тайлбарлан өгч, түүнчлэн Ар Монголын хувьд хууль эрх зүй, боловсрол, ариун цэвэр, үйлдвэрлэл болон бусад зүйлийн хөгжилд чармайж, өөрийгөө баян бөгөөд хүчирхэг болгох төлөвлөгөөгөө биелүүлэх нь одоогийн тулгамдсан зорилт чинь шүү хэмээн хувийн зөвлөгөө өгсөн. Тэгээд цааш нь дээр дурдсан боловсрол болон үйлдвэрлэлийн хөгжлийн тухай цаашид тохиромжтой цаг үед эсхүл Япон боломжийн тусламж үзүүлж болохоор болж магадгүй гэсэн ч одоохондоо юу ч амлаж чадахгүй гэдгийг хэлсэн.

Нэмж хэлэхэд, Жавзандамба хутагтын элчээр хоёр хүнийг томилон явуулсан боловч нэг хүн нь Бээжинд баривчлагдсан бололтой. Мөн ч бас саяхан Ар Монголын хааны гэр бүлээс хоёр хүн дээрх даалгавар гүйцэтгэхээр Япон руу томилон илгээсэн боловч замдаа улаан цэргүүдэд баривчлагдаж алагдсан сурагтай”⁶²

хэмээн бичсэн байна.

⁶² Японы Гадаад яамны дээрхи баримт, т.511329-511320

Японы Гадаад хэргийн яамны Азийн хэргийн товчооны даргын дээрхи тэмдэглэлээс үзэхэд, ямар нэгэн монгол хүн уг бичгийг авчирч өгөөд дээш нэвтрүүлэхийг ихэд чармайсан бөгөөд Монголын цаашид хэрхэн авч явах талаар зөвлөмж авахыг хүсчээ. Богд хааны элч хэмээн хоёр хүн томилогдсон боловч нэг нь Бээжинд баривчлагдсан учир Японд хүрэлцэн очиж чадаагүй байна. Зарим судлаачид Цэрэнпил Хятадад нэг удаа баривчлагдсан боловч зугтаасан бөгөөд төдөлгүй өвчний улмаас Хятадад нас барсан. Цэвээнноров нь Цэрэнпил болон хувирч Японд очиж захидлыг хүргэсэн, дараа нь Хятадад бүгэж байгаад Дотоод яамныханд баригдсаж устгагдсан гэж таамагладаг амуй. Цэрэнпилийн дараа Японоос тусламж гуйх гэж санаархсан өөр хүмүүс мөн л Богд хааны нэрийг барьж байсан тухай Азийн хэргийн товчооны дарга Ёшизава илтгэл бичжээ.

Монголын хүсэлтийг Японы эзэн хаанд уламжлах боломжгүй гээд харин Гадаадхэргийн сайдадуламжлахадөнөөгийн олон улсын харилцааны төлөв байдлаас хамааран Монголын хүсэлтэнд хариу өгөх боломжгүй гэдгийг шууд мэдэгдсэн хэдүй ч⁶³ энэ удаад Япон Монголын тухайд ямар бодолтой байдгийг илтгэжээ. Мөн найрсаг зөвлөгөө өгсөнөөр эл хэрэг төгсгөл болжээ. Японы тал ийм хариу өгсөн тухайд Монголд тэр үед ямарч мэдээлэл байсангүй. Японы тал ийм хариу өгсөн талаар Онон Өргөнгө өгүүлэлдээ тайлбар хийхдээ,

“Гэгч Монголчууд хэдэн ч удаа Японоос тусламж гуйсан ч Япон зөвшөөрөхгүй. Учир нь тэр үед (1911-1923) Монгол нь Япон-Оросын хооронд 1907 онд Гадаад Монгол, Өвөр Монгол болон умард Маньчжурт нөлөөний хүрээгээ хуваан тогтоосон гэрээ байгуулсан байсан юм”⁶⁴

гэж бичсэн нь үндэслэл болохгүй аж. Учир нь Зөвлөлт Орос улс 1918 оны 1 сарын 21-нд (2 сарын 3) Хаант Орос болон Түр засгийн газраас гадаад орнуудтай тогтоосон бүх гэрээ хэлцэл болон гадаадын өрийг хүчингүй болгосон байсан билээ. Харин захидалд өгсөн хариунаас үзэхэд Хятадаас⁶⁵ Япон улс болгомжилж байгаагаа энэ удаа дахин онцлон дурьдсан байна.

Энд нэгэн зүйлийг тодруулан хэлхэд, дээр дурьдсан Үсүки Масүзоо (1878-1940)⁶⁶ гэгч хүн бол 1916 онд Бавуужавын цэрэгт элсэн байлдаж явсан, Өвөр Монголд өөрийн пүүстэй, бизнес эрхлэн амьдардаг нэгэн байсан агаад энэхүү Монголыг сайн мэдэх хүнээр захидлыг хүргэхээр явж буй монгол хүн газарчлуулан Японы Гадаад хэргийн яаманд очжээ.

⁶³ Анх Харбинд очин хэрэг зоригоо хэлхэд мөн л ийм хариу өгсөнийг өмнө дурьдсан билээ.

⁶⁴ Онон Өргөнгө дурьдсан өгүүлэл. Т.72

⁶⁵ Өгүүлэн буй үед Монголын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд де-Юре хүлээн зөвшөөрөөгүй байсан. Хятад нь Монголыг өөрийн нэгэн хэсэг хэмээн үзэж байв. 1921 онд Зөвлөлт Орос Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, найрамдал хамтын ажиллагааны гэрээ байгуулсан хэдүй ч Монголын ар хударгаар 1924 онд Хятадтай “Монгол бол түүний нэг хэсэг” хэмээн харилцан тохиролцсон нууц гэрээ байгуулсан байсан юм.

⁶⁶ Kuchigi Hanzou, Bazoku Tenki shougun den. Tokyo, 1981

Дүгнэлт

“Гүн Цэрэнпилийн хэрэг” хэмээн манай түүх бичлэгт тэмдэглэгдэн үлдсэн эл хэргийн тухайд судлаачдын бичсэн зүйл болон Японы эзэн хаанаас тусламж хүсэн бичсэн Өргөх бичиг болон түүнд дагалдуулан илгээсэн бичиг зэргээс үзэхэд Хэмжээт цаазат Ардын эрхтэй Монголын засгийн газрын бодлогод дургүйцэж байсан хэсгийнхэн бол хуучин эрх ямбаа алдсан язгууртан хэргэмтнүүд болон гавчигдан гадуурхагдаж байгаа лам хуврагуудаас гадна шинэ цагийн төлөөлөл болсон нийгмийн дундач давхаргынхан болох төрийн албан хаагч түшмэдүүд, бичиг номын хүмүүс, энгийн ардын төлөөлөл ч эл хэрэгт холбогдон оролцсон байна. Энэ нь улаан оросын бодлогыг дагалдан уламжлалт бодлогоо алдаж улаантнуудыг дур зоргоор явж буй тэр хэсгийнхэнд нийгмийн зүгээс эсэргүүцэн дургүйцэх, улмаар тус орны ирээдүйд илтгэл алдрах байдалд хүргэж буй илэрхийлсэн, Монголоо монголоор нь байлгах гэсэн хүчнийхний санаа бодол, хүсэл тэмүүллийг илэрхийлсэн байжээ. Үүнийг илгээсэн бичгүүдийн агуулга бүрнээ илэрхийлж байна. Эл бичгийг шийтгэгчид Японы талаас зэр зэвсэг, цэргийн хүчнийг Монголд оруулхыг хүссэн нь тун ч эрс шийдэмгий хүсэлт байсан гэлтэй боловч нөгөө талаар эл хүсэлт нь тухайн үед ямар ч амжилтанд хүрэх боломжгүй гэдгийг ухааран сэхээрэхгүй байсан нь өрөвдөлтэй мэт.

Монголчууд Япон улсаас ХХ зууны 13-20-иод оны үеэд нэг биш удаа тусламж дэмжлэг олохыг хүсч оролдож байсан билээ. Гагцхүү тухайн үеийн олон улсын харилцааны байдал хийгээд Монголыг Хятадын нэгэн хэсэг хэмээн батлан байгуулсан гэрээ хэлэлцээрүүд нь Японы зүгээс Монголын асуудалд нааштай хандах явдал саад хотгор учруулж байсан аж. Эл явдлыг бидний өгүүлж буй баримтуудад тодорхой тусгагджээ. Мөн Японы зүгээс Монгол улсын одоогийн зорилт бол өөрөө хүчирхэг болж, хөгжлөө түргэтгэх явдал шүү хэмээн зөвлөхийн ялдалд ирээдүйд бас ч Монголд боловсрол болон үйлдвэрлэлийн хөгжлийн тухай цаашид тохиромжтой цаг үед Япон улс боломжийн тусламж үзүүлж болохоор болж магадгүй гэсэн ч одоохондоо юу ч амлаж чадахгүй гэдгээ илэрхийлсэн нь өнөөдрийн өндөрлөгөөс эргэн хархад тэр үед ихэд л зөнч зүйл хэлжээ. Өнөөдөр Япон улс нь Монгол улсад үзүүлсэн тусламжийнхаа хэмжээгээрээ бусдыг хошуучилж хамгийн том хандивлагч орон нь болсны зэрэгцээ Монголын ардчилал зах зээлийн эдийн засаг руу шилжих үйл явцыг тууштай дэмжсээр ирсэн⁶⁷ аж.

Abstract: Mongolia just after establishment of its new statehood has an accident in 1922-1923 in which Mongolia itself and China and Japan were involved. In Mongolian history named it as “Tserenpil’s case”. In my article I described how this case was described in the historical

⁶⁷ Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт сайд Такэнори Шимизү тус хоёр орон дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг тохиолдуулан нийтлүүлсэн “750 жилийн тэртээгээс улбаатай Япон, Монголын орчин үеийн харилцааны 40 жил” өгүүллээс эш татав. \\\ mn.emb-japan.go.jp\

literature. I found a letter to the Japanese Emperor by governor “Manzushiri Khutugtu of Mongolyn aimag sabyg barigchi” dated back to the 25th day of the first month of the 12th year of all elevated of Mongolia with the attachment “Proposal of the Moscow revolutionary youth meeting to the Mongolian People’s Government” dated the 11th month of 11 year of all elevated Mongolia”. Only two historians wrote about this letter. But in my research paper I did a textology research. Historians didn’t mention about existence of such attachment to the letter. That letter and attachment shows how the Mongolian society of that time got the influence from outside namely Moscow. This letter to the Emperor of Japan was seeking the support from Н.Е. The attachment to the letter I translated into modern Mongolian and submitted to the article.

Хавсралт: Өргөх бичигт хавсаргасан бичиг⁶⁸

Өргөн толилуулах нь

Монгол улсын Олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны арван нэгэн сараас эхлэн Ардын засагт хэмээх олон намын Оросын Москва хотноо хуралдсан Залуучуудын эвлэлийн хүмүүсийн зөвлөлдөн хэлэлцсэн саналын хуулбар.

Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын их хурлын газраас Рибэн, Хятад, Гуулин, Монголын залуучуудад тусгайлан зарлах бичиг.

Нөхдүүд таны Дорнодын Рибэн, Гуулин, Хятад, Монголын залуучуудын төлөөлөгчөөр хөдөлмөрчин ардын эрхтэй Зөвлөлийн засагт Орос улсын улаан Москва хотноо хуралдаваа. Биднар мөнхүү Москвадирж Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын хурал хэмээн нээсэн нь биднар өөрсдийн зовлон зүдгүүрийг тоолон хэлэлцэж, үүнээс хойш хэрхэвээс, эзэрхэг этгээдтэй тэмцэлдвээс зохих зүйлийг төлөвлөгөсүгэй хэмээжэхүй. Тиймийн тул бидний Дорнодын олон залуучууд тус тусын байдлаа шүүмжлэн үзэхэд ядуу буурай байдлаас хэрхэн хэлтрэх замыг урьдаас нарийвчлан олно. Эдүгээ бүх Дорнодын олон улсын дарлагдсан байдал нь

⁶⁸ *Diplomatic Archives of the Ministry of Foreign Affairs of Japan*. Code: B03050172300. Subseries Key B-1-6-1-142. Pp.51142-51183 Энэхүү бичгийг захидалд хавсарган явуулсан нь Зөвлөлт Оросын зүгээс Монголын залуучуудыг хувьсгалт үзэл санаагаар хордуулах бодлого баримталж байна гэдгийг илтгэх зорилготой байжээ. Мөн танай Япон улсыг бас ингэж муучилж байна шүү гэдгийг илтгэсэн бололтой. Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хуралд Монгол, Хятад, Индонез болон Зүүн болон, Зүүн Өмнөд Азийн орнуудын 9 орны таслах эрхтэй төлөөлөгч, зөвлөх эрхтэй 17 төлөөлөгчдийг Зөвлөлт Орост аваачин тэднийг большевик, коммунист үзэл суртлаар тархи нь угааж, даян дэлхийд пролетарийн хувьсгалыг ялуулах зорилтоо биелүүлэхийн тулд зохион байгуулсан хурал юм. Эл өдөр АНУ-д Вашингтоны бага хурал нээгдэж байсан агаад үүнийг нь сөргүүлэн тус хурлыг зохион байгуулж, “шинэ аюул” гэгчийн эсрэг Алс Дорнодын хөдөлмөрчин ардуудыг нягтруулах үүднээс хийж буй хурал хэмээн мэдэгдэж байв. Хурлын төлөөлөгчид намын болон залуучуудын хэмээн 2 секц болон хуралджээ. Монголоос 14 төлөөлөгч оролцсоны Ардын намын 6 төлөөлөгч, залуучуудын эвлэлийн 8 төлөөлөгч байжээ. Хамгийн олон төлөөлөгч нь Солонгосынх байжээ. Олон орны төлөөлөгчид В.И.Ленинтэй уулзсан болой.

хэвээр буй бөлгөө. Рибэны капиталт эзэрхэгүүд Гуулин⁶⁹ улсын хамаг эрхийг нь авч, цэргийн хүчээр түүний ард түмнийг хавчин хяхаж, цусан тамирыг шувтран авч Рибэний эзэрхэг капиталт нарын идэш болгожихуй. Гуулин улсын эдүгээгийн хувьсгалч эрсүүд Рибэний эзэрхэгүүдийн эсрэг, дарлалаас мултрах хэмээн журмын туг дэлгэн хөдөлсөн нь үүнээс хойш удалгүй хүнд тэмцэл үүсгэсэн бөлгөө.

Хятадын байдлыг хэдийбээр хүмүүн үзэхэд эрх чөлөөтэй мэт боловч үнэндээ бусдын эзэрхэг улсуудын эрх байдлыг хүндэд хүлээжэхүй. Юухэмээвээс, эзэрхэг Рибэн улс бөгөөс их цэргийг түүний газарт түлхэн оруулж, хүч сүрээр Думдад Хятадыг хөдөлгөлгүй түрэмгийлсэн ба Америкийн эзэрхэгүүд ба капиталт нар болвоос тэдгээр орон бүрт худалдааны хороо дэлгэн байгуулсан нь Хятадулсыг гадаадын капиталт эзэрхэгүүдийн идэш болох үүдийг нээсэн нь илэрхий буй.

Тэдгээр эзэрхэг этгээдүүд хэдийвээр аман дээр ардуудын эрхийг дэлгэрүүлмөй гэдэг боловч биендээ хутгыг өвөртөө нуучихуй.

Жич, Хятадын байдлыг урьдчилан үйлдсэн мужийн эзэд ихэс ноёдууд тус улсын ард түмнээ мөн ч дотоодоос дарлан сууж буй. Харин өмнөд муж тэдгээр дотоодын эзэрхэгүүд бас шилжүүлсэн боловч басчуу түүний засгийн эрхийг хөрөнгөтөн нар эзэлчихүй⁷⁰. Эдүгээ аваас Дундад улсын үйлдвэрийн ард түмэн ану эвийн хоршоондоон нэгдэн⁷¹ чадаж байхыг үзвээс удалгүй гадаад, дотоодын эзэрхэг этгээдээ устгаад бас тэдгээр капиталтан нар лугаа тэмцэлдэх явдал үүсгэх буй за. Тэр этгээд ану дарагч түүний зовлонтой тариалангийн ард дор харилцан тусалцах хэрэг бүтэх бөлгөө.

Бас энэхүү хуралдаан дор илэрхийлсэн нь: Жич, танай улсыг сонсохоор эдүгээгийн хүмүүн бүр Вашингтон хэмээн түрхэрсэн нь, тэрхүү хотод⁷² юухэлэлцэн бэ хэмээвээс, дэлхий дахины зэр зэвсгийг хураах ба Гуулин улсын дарлагдсан заргыг илэрхийлэх ба Хятадын будлианыг⁷³ тэгшитгэх хийгээд Алс Дорнодын ардулсуудын амар тайван болгомой хэмээн хэлэлцэжчихүй. Үүнд, Дорнодын зарим ухвар үгүй улсууд бидэнд үнэхээр тус болох болов уу хэмээн итгэсэн болой.

Ер ойрх онуудаас хойгуур арга үүсгэсэн газруудыг нягтлан хянахад

⁶⁹ Монголчууд Солонгос улсыг Гуулин улс хэмээн нэрлэдэг байсан

⁷⁰ Хятадад эл үед хоёр засаг тогтож байв. Бээжинд цэргийн эрхтнүүдийн засаглал, өмнөд хэсэг Гуанчжоуд Сүн Ятсены засаглал тогтож байв

⁷¹ Хятадын Коммунист нам 1921 онд Коминтерны тусалцаатайгаар байгуулагдсан бөгөөд 1921 оны 6 сарын сүүлч 7 сарын эхээр Шанхай хотноо нууцаар анхны Их хурлаа хуралдуулж, тус оронд социализм байгуулах явдлыг өөрийн эцсийн зорилт хэмээн тодорхойлсон байна.

⁷² Вашингтоны бага хулыг АНУ санаачлагаар 1921 оны 11 сарын 12-ноос 1922 оны 2 сарын 6-ны хооронд хуралдуулсан бөгөөд түүгээр усан цэргийн зэвсэглэлийг хорогдуулах болон Алс Дорнод болон Номхон далайн сав газрын асуудлуудыг хэлэлцсэн. АНУ, Их Британи, Хятад, Япон, Франц, Итали, Бельги, Нидерланд, Португали болон Британи 5 доминион орон оролцжээ.

⁷³ Вашингтоны бага хурал дээр Хятадын асуудлыг “Есөн гүрний хэлэлцээр”-ээр зохицуулж, Хятадын газар нутгийн бүрэн бүтэн байдал, халдашгүй эрхийг тунхаглахын хамт худалдаа арилжааны салбарт тус оронд “нээлтэй хаалга, тэгш боломжийн бодлого” хэрэгжүүлэхээр тогтжээ. Мөн тус оронд өрнөх аливаа дотоодын хувьсал хөдөлгөөнд гаднаас оролцохгүй байхаар харилцан тохиролцжээ.

Америк улсын эзэрхэгүүдийн эрхгүйд холбогдсон байдаг тул энэхүү америкийн дээрэмчин нар бүх араа, халхавчаа өмнөө бариад ниргэдэг нь илэрхий болсон бөлгөө. Юу хэмээвээс, урьд Америк улсын Вудро Вильсон⁷⁴ Дорнодын олон буурай улс ба дэлхий дахины олон ардад эрх чөлөө олгож жаргуулмой⁷⁵ хэмээн дэмий донгодсон хийгээд одоогийн дэлхийн эзэрхэг харгисууд мөн Дорнодын олон улс ба дэлхийн ардтүмэнд эрх чөлөө, аргат байдлыг олгуулмой хэмээн сайхан илбэ гаргаж байх зэргийг зүйлүүдийг удирдаж буй хэмээвээс энэхүү Америк улс бус уу буюу. Тиймийн тул Дорнодын олон зүдрэн зовсон улсууд ба дэлхий дахины буурай улсууд Вудро Вильсоны уран аргад мэхлэгдсэн лугаа адил басчуу эдүгээгийн цэргүүдийн элдэвчилхүй аргыг итгэж санах зарим нь байх магадгүй буй за. Тиймийн тул эдүгээ бид нар Вашингтонд хэлэлцсэн зүйлийг илэрхийлж болох бөлгөө. Үүнд, 1921 оны 12 сарын 10-ны өдрийг санаваас хүмүүн бүхний гамшиг эвдрэлт өдөр хэмээвээс болмой. Энэ өдөр хэмээгч дэлхийн амьтныг дарлагч нэн эзэрхэг түрэмгий Америк, Рибэн, Франц мэтийн улсууд Вашингтонд сүлбээлдсэн өдөр хэмээн тэмдэглэгдэх болой.

Жич, эдгээр эзэрхэгүүд бүгдадил үгүй эвдрэл тэмцэл болж байлдаан үүсгэх боловч энэхүү эвлэл хуралдсан хэмээгч дор алгуурлаж зэр зэвсгээ хурцасган бэлтгэх ба тэдгээр дарангуйлагдсан олон улсуудыг улам атгандаан бэхлээд, дахин цусан аллагт байлдаан үүсгэхийг бэлтгэхийн арга болой. Вашингтоны нэн тэргүүнд хэлэлцсэн зүйлүүдэд дэлхийн зэвсгийг хураах хэмээсэн бөгөөд эдүгээ харин улам дэгжээхийн тухай хэлэлцсэн нь илэрхий болжихуй.

Та нар тэдгээр эзэрхэгүүдийн хэлэлцсэнийг тодорхой сонссугай хэмээвээс тэрхүү түшмэлээс огцорсон Францын тэргүүн сайд Бриан⁷⁶ мэт эзэрхэгүүдийн хоорондоо хэлэлцсэн нь бид нар хичнээн усан цэрэг, цэргийн онгоц тэргүүтнийг бэлтгэхэд болох бөлгөө хэмээх мэтээр хэлэлцэн суужээ. Эдгээр эзэрхэгүүд энэ мэтийн хэргийг санамсаргүй хэлэлцэн суухыг Дорнодын олон ардууд хэзээнээ үзэж сонссоор байхыг гэнэт үзээд тэр мэт хэлэлцсэн ил байлгахын тул их л нийцэлдэн хэлэлцсэн нь бидний усан цэрэг хэмээгч их далайн эрэг дээрх эрдэнийн чулуутэргүүтнийг нэгжин авахад хэрэгтэй хэмээгдэжихүй. Тиймийн тул эзэрхэгүүд зэвсгээ хураамой хэмээгч хуурмаг явдлыг хэн ч мэдсээр үл мэдэх нь илэрхий бөгөөд харин бидний эв хамт намын ардаас хэлэлцэх үгэнд энэ дэлхийд эзэрхэг капитал байсан цагт байлдаан тэмцлээр зэвсэг хураагдах их бэрх бөгөөд зарим дэлхийн олон дарлагдсан ардуудын эрх мэдлээ авбаас сая зэр зэвсэг хураагдмой хэмээсэн нь энэхүү хурал хэмээгч дахин баталсан лугаа адил болох

⁷⁴ Вудро Вильсон (1856-1924) АНУ-ын 28 дахь ерөнхийлөгч. 1919 онд энх тайвныг сахиулах үйлст оруулсан хувь нэмрийг нь үнэлж Нобелийн шагнал хүртээсэн.

⁷⁵ 1918 он. “Вудро Вильсоны 14 зүйл” ийг хэлж байна. Ерөнхийлөгч Вильсоноос дайны зорилгыг тодорхойлсон баримт. Тэдгээр 14 зүйлийн 4 нь л амьдралд хэрэгжсэний нэг нь “Үндэстнүүдийн холбоо” байгуулагдсан явдал байлаа.

⁷⁶ Бриан, Аристид (1862-1932)- Францын гуравдахь Бүгд Найрамдах засгийн төрийн зүтгэлтэн. Тэрээр тус улсын ерөнхий сайд, Гадаад хэргийн яамны сайд, Шүүх яамны сайд, Дотоод хэргийн яамны сайдын албыг тус тус хашиж байсан. 1926 онд Нобелийн шагнал хүртсэн.

бөлгөө. Үүнд, Дорно зүгийн явдлыг хэрхэн шийтгэхээр тогтоосон буй хэмээвээс, жич Солонгос улсын зэргийг хэрхэн шийтгэх буй хэмээн асууваас Солонгос нь⁷⁷, Солонгос улсын заримууд нь Вашингтоны хурлаас үзэхүүл тус үл болох хэмээн горьджихуй. Үүнийг илэрхийлбээс модоор буу хийж дугаргах болов уу? хэмээн итгэсэн лугаа адил болжихуй хэмээхээс гадна энэ мэтээр эрмэлзсэнийг үзсээр бөгөөд өчүүхэн ч тус хүргэсэн үгүй хэмээх ч байтугай тэрхүү хуралдаанд Гуулин хэмээх үсгийг ч дурьдсан ч үгүй нь үнэхээрийн дэлхий дахинд Гуулин улс хэмээгч үгүй дор адил хэмээсэн бөгөөд харин хурлын гадуур басхүү Гуулин улсыг яахан боолчлохыг бодолхийлдэг буй за. Тиймийн тул Гуулин улсад үүнээс илүү гомдох гэмшил үгүй болой. Жич, Хятадын хэргийг Америк улсын саналыг дагахаар хэлэлцсэн хэмээнэ.

Бас энэ хурал дах эв хамтын үндэстний их чуулган Интернационалын⁷⁸ гүйцэтгэгч яамны тэргүүн Зиновьев⁷⁹ даргын айтгал:

Нөхөдөө, миний таны олны өмнө эдүгээ цагийн дэлхий дахины олон улсын байдлыг энэхүү хурлын зэргэлдээд нийлүүлэн илэрхийлэх ба жич танай хурлын уг зорилтыг Интернационалын бодлогодуюнь хэмээж буйг хамтатган айлтгасугай. Эдүгээ бөгөөс дэлхий эзэрхэгүүдийн их байлдаан төгссөөр гурван жил болсон боловч мөн үүний урьд үхэж сүйдэж үхсэн нь ану үргэлжид марташгүй болсон нь хэмээх ч байтугай одоогийн хүн төрөлхтөн бээр эдгээр эвдрэл цочирлоос тонилсугай хэмээж бүхий нь торон дотор хорьсон шувуу цовхрох лугаа адил болжихуй.

Жич, би санаваас энэхүү их байлдаанаас хойш нэгэн зүйлийн шинэ явдал үүсчээ. Энэ нь гагцхүү Европын байдлыг хэлэлцдэгээс хэтрээд уламлан Дорнодын Ази тивийн аливаа явдалд хэтэрхий хэлэлцэх болсон буюу холбогдох болж буй. Миний энэ хэлсэн нь ану урьд бөгөөс Ази тивийн явдлыг олон улсын хэрэгт оролцдоггүй хэмээсэн бус болой. Мөн ч холбогдон агсан боловч нэн ялангуяа эдүгээгийн цагт үлэмж холбогдсоныг таны олон ч мэдсээр буй за. Тэрч байтугай та нар үзсээр атал 1904-1905 онд Алс Дорнодын аливаа хэргийн тул Орос-Рибэны⁸⁰ тэмцэл үүсч байлдаан дэгдсэний дараагаар Оросын дотоод төр

⁷⁷ 1904-1905 оны Япон-Оросын дайны дараа Япон Солонгост протекторат эрх тогтоосон. 1910 онд түүнийг бүр мөсөн өөртөө нэгтгэсэн ба 1910-1945 онуудад Солонгос нь Японы колони орон байв.

⁷⁸ III Интернационал буюу Коминтерныг хэлж байна. 1919-1943 он оршин тогтнож байсан. Олон орны коммунист намуудыг нэгтгэсэн олон улсын байгууллага бөгөөд дэлхий дахинд пролетарийн хувьсгал ялуулахад төв штаб (ялангуяа байгуулагдсаныхаа эхний жилүүдэд) болох зорилготой байсан.

⁷⁹ Зиновьев, Григорий Евсеевич (1883-1936)-Оросын хувьсгалч, Зөвлөлтийн улс төрийн зүтгэлтэн. 1919-1926 онуудад Коминтерны Гүйцэтгэх хорооны даргаар ажиллаж байсан. 1927 онд намаасаа хөөгдөж цөлөгдөж байсан боловч 1928 онд намын гишүүнчлэл нь сэргээгдэж улмаар Казаны их Сургуулийн захирлаар ажиллаж байсан. 1934 онд “Москвгийн төв” хэрэгт холбогдон баривчлагдан дахин намаасаа хөөгдөж, 10 жил шоронд хорих ялаар шийтгэгдсэн бөгөөд мөн 1836 онд түүнийг “Троцкий-Зиновьевийн төвийн” хэрэгт холбогдуулан цаазалсан. 1988 онд цагаатгагдсан.

⁸⁰ 1904 оны 2 сараас 1905 оны 9 сарын хооронд дэгдсэн Япон-Оросын дайн нь Манжуур болон Солонгост нөлөөгөө тогтоохын төлөө хийсэн дайн. Япон дайныг эхэлсэн ба мөн түүний ялалтаар дуусч Портсмутын найрамдлын гэрээ байгуулж, түүгээр Хаант Орос улс Сахалины өмнөд хэсэг, Ляондуны хойг болон Өмнөд Манжуурын төмөр замын түрээсийн эрхээ Японд алдсан аж.

хувьсгал⁸¹ гарсан бус буюу. Тиймийн тул үүнээс хойш хэдэн үе хүртэл Алс Дорнодын аливаа хэргийг хэргийн түрүүнд хэлэлцэхэд хүргэх болой. Үүнийг та нар эс итгэх аваас олон улсын Эвийн хурлаас⁸² янагш үүссээр ирсэн тэмцлийг хянаваас даруй мэдэх байжээ. Тэр ч байтугай ойрх мэдээнд сонсвоос гагцхүү Франц улсын ерөнхий сайд Бриан бээр тушаалаас огцорсны улмаас Итали улсын Генуя⁸³ хотод цугласугай хэмээсэн олон улсын холбооны хурал эдүгээ бүтэх эс нь мэдэгдэхгүй болжихуй. Европын олон улсууд дотооддоо булаалдах юм ану ховор болсон нь гэрч бус уу буюу.

Жич, их байлдаанаас Герман улсыг дийлсэн этгээдээс нэн ялангуяа баялаг Франц улс бээр Германаас байлдааны төлбөрийг⁸⁴ эдүгээ хүртэл бүртгэн авч чадаагүй буй хэмээхээс гадна өчигдрийн сонин бичгийн дотор та нар үзээгүй дээ. Түүний дотор Франц улсын ерөнхий сайд Пуанкаре⁸⁵ өгүүлсэн ану. Эдүгээгийн хүмүүс бүр бидний Франц улсыг галзуу эзэрхэг хэмээдэг ажгуу. Үүнд бидний зам ану ганц Герман улс лугаа урьдын хэлэлцсэн гэрээний доторх өр төлөөсөө авсугай хэмээсний учраас бусад өөр гэм үгүй болой хэмжээхүй. Үүнийг хүн санахад үнэхээр өрөө авсугай хэмээх нь зүйтэй мэт санагдавч үнэндээ Герман улс энэ өрийг төлөх чинээ огт үгүй тул Франц улс өдөр бүр төрийн сайдаа сольж, өрөө нэхсүгэй хэмээвч Герман улсын хөрөнгө тэрчлэн тэнцэхийн аргагүй болой. Энэ мэт хэрэг хэдийвээр багахан мэт боловч Европын олон улсын хоорондын булаалдал их болсны нэгэн тэмдэг байжээ. Тийнхүү өнгөрсөн их сүйтгэлт байлдаан бөгөөс зөвхөн Европын улсуудын тэрхүү зуураа тогтоход тохируулсан тул дийлсэн улс нь дийлэгдсэн улсаасаа өрөө авахад бэрх болжихуй. Жич, энэхүү эзэрхэг түрэмгий их байлдаан дэгдсэний учирт Ази тивийн явдал мөн холбогдсон боловч их төлөв Европын эзэрхэгүүдийн хоорондох тэмцлийн учраас болой.

Жич, энэ мэтийн хүмүүн төрөлхтөнд урьд үзэгдээгүй их дайн байлдаан үүсээд төгссөний хойно тэдгээр дийлсэн ба дийлэгдсэн улсууд эдүгээ үзвээс Европ

⁸¹ 1905 оны 1 сараас 1907 оны 6 сар хүртэл Оросын эзэнт гүрэнд гарсан анхны хувьсгал.

⁸² Дэлхийн нэгдүгээр дайны төгсгөлийн энхийн гэрээ буюу Версалийн найрамдлын гэрээг хэлж байна.

⁸³ 1922 оны 4 сарын 10-аас 5 сарын 20-нд Италийн Генуя хотноо хуралдсан. Хуралд 29 орон, Британы 5 доминион улсын төлөөлөгчид оролцсон. Төв болон Дорнод Европын эдийн засгийг сэргээн босгох асуудлыг хэлэлцсэний хажуугаар Зөвлөлт засаг Хаант Орос улсын бүр өр ширийг төлөх ёстой гэсэн шаардлагыг Оросын төлөөлөгчдөд тавьсан агаад Зөвлөлтийн тал хэрэв Зөвлөлт улсын де-Юре хүлээн зөвшөөрч түүнд зээл олговол тэднийг шаардлагыг хүлээн авч болох юм гэж мэдэгдэхэд хилийн чанадад дүрвэн гарсан оросууд үүнийг эсэргүүцсэн мэдэгдлийг Генуягийн хуралд тавьсан байдаг

⁸⁴ Дэлхийн нэгдүгээр дайн (1914-1918) ялагдсан Герман болон түүний холбоотнууд Версалийн найрамдлын гэрээний дагуу ялагч орнуудад 269 млрд. алтан марк буюу 100 мянган тонн алттай тэнцэх дайны төлбөр төлөх ёстой болсон байв. Гэвч төлбөрийн асуудлыг удаа дараа хэлэлцсэний эцэст 132 млрд алтан марк болгож буулгасан байна. Энэ төлбөрийг 2010 онд төлж дууссан. Дайны үйл ажиллагаа нутаг дэвсгэр дээр нь хамгийн их явагдаж, дайны хөлд нэрвэгдсэн Франц улс уг төлбөрийн үлэмжхэн хэсгийн авах ёстой байсан аж

⁸⁵ Пуанкаре, Раймон (1860-1934)- Францын улс төрийн зүтгэлтэн, Францын гуравдахь БНУ-ын ерөнхийлөгч (1913-1920)

хэмээгч дэлхийн бөмбөрцгийн нэгэн өчүүхэн газар тул энэ байлдаан хэмээгч аяганы доторх ус цалгисан мэт адил болой хэмээн итгэн санадаг болжихуй. Тиймийн тулд үүнээс хойш Европт эзлэн түрэмгийлэх их тэмцэл дайн гарах нь арилсан боловч харин Алс Дорнодын Ази тив бөгөөс эдүгээгийн дэлхийн эзэрхэг түрэмгий нарын байлдааны орон болохыг завдан буй. Энэхүү учраас Ази тивийг эдүгээгийн цагт дэлхийн олон эзэрхэгүүдийн 100 түмэн хувь шунахайрахын хамтаар гадна дарлагдсан олон бага буурай улсууд ба дарлагдан мөлжигдсэн олон ард түмэн ч эрх чөлөөгөө хүсэх маш их хэргийн орон болжихуй.

Ойрх онуудын түүхэнд Брусель, Гаага, Сен-Жермен, Версаль зэргийг хотуудыг нэрлэвээс дэлхийн эзэрхэгүүдийн сүлбээлдэн явсан нь доройтсон лугаа адил бөгөөд эдгээр хотуудын зэрэгт эдүгээ биш нэг хот нэмэгдэн гарсан нь ану Вашингтон мөн болой. Тиймийн тул эдүгээгийн Вашингтон бөгөөс Ази тивийг дарлан мөлжих төв ашиг болсон болой. Нээх мэт шийтгэж өгөхүй⁸⁶ энэ бол Америк улсын шунахай сэтгэлийн үүднээс үүсгэсэн хэрэг болой. Түүний санал ану бид нар худалдаагаа бусад улсуудтай хамтаар Хятадад нэвтрүүлэн худалдаалах эрхтэй бөгөөд бид нар хүчирхэг тул эцэстээ бусад капиталтныг түлхээд бидний эд дэлгэрэх болой хэмээн санадаг болой. Юу хэмэвээс урьд 1916 онд Америк Хятадад худалдаалан орсон нь нэгэн зуун наян ёсон сая төгрөгийн худалдаа гүйлгэдгийн хойно 1920 оны үеэс 382 сая төгрөгийн худалдаа оруулах болж буй. Энэ нь 2 хувь нэмэгдсэн бус уу буюу. Энэ мэтийн учраас эрхгүй бусад улсын капиталтнаас илүүгээр Хятадын ашгийг олж болмой хэмээн итгэдэг тэмдэг болой. Тиймийн тулд эдний энэ мэт тэгш эрхтэйгээр худалдаалан орохыг зарим Хятадын ухваргүй хүмүүс сайн болгон санах аваас маш их эндэгдэл бөгөөд эцэстээ гадаадын капиталтны өгөөшид эрхгүй орно.

Жич, миний бие маш уйтгартай нэгэн зүйлийн хэрэг сонссоноо цагаадлаг ану. Дундад улсын өмнөд засгийн газрын Сүн Ятсены⁸⁷ намын зарим хүмүүс нь Вашингтоны хурлаас бидний Ардын засаг ба ард түмний эрх мэдлийг дэлгэрүүлэх явдалд туслах болой хэмээн итгэдэг ажгуу. Эдүгээ санаваас Вашингтоны хурал төгссөнөөс өмнө Хятадын хувьсгалч⁸⁸ нар итгэхээ байсан буй за. Тиймийн тул Америкийн капиталтан бээр үнэндээ бидний хортэтгээд мөн болой. Тэд нар бөгөөс бусдыг мөлжихдөө хэрэг ану. Бид хэмээгч ардын эрхтэй улс болой. Тиймийн тул ард түмний эрхийг дэлгэрүүлэх явдалд тусалмой хэмээн мэхэлж дарлан эзэрхдэг болой.

⁸⁶ Нээлттэй хаалганы бодлогыг хэлж буй. Энэ нь колонийн бодлогод, ялангуяа Хятадад тэгш боломжийн бодлого баримталъя гэсэн АНУ санал байлаа.

⁸⁷ Хятадын Консерватив нам болох Гоминьданы намыг үндэслэн байгуулагч Сүн Ятсен 1920 онд Гуанжоуд засгийн эрхийг авсан байв.

⁸⁸ Коминтерн II (1920.7-8 сар) их хурлаас Дорно Дахинд явуулах бодлогоо тодорхойлж, тус бүс нутагт хувьсгалын үзэл санааг дэлгэрүүлэх 3 том төв байгуулсны нэг нь Шанхайд төвлөж байв.

Монголын тухайд бөгөөс Вашингтоны хуралд мартчихуй. Монгол улс⁸⁹ бөгөөс Зөвлөлт Оросын бага тусламжаар бага тэнхэрсэн бөгөөд бид ч тусласнаа нэг ч нуухгүй. Харин бага буурай улсыг бидний улаан цэрэг бага ч болов туслаж буй хэмээх илэрхий алдартай болсон нь ану сайн болой. Эдүгээгийн эзэрхэг түрэмгий нар бээр Монгол улсыг хоорондоо бөмбөг наадах мэтболгосонд эзэрхэг Рибэн улс ч бас Монголыг мөн нэгэнтээ наадсугай хэмээнэ. Хятадын харгис этгээдийг эд мөнгөөр аргадан монголчуудыг Хятадад эргүүлж авч Их улс байгуулбаас зохимой хэмээх мэтийн явдлыг үүсгэнэ. Хятад, Монголын хувьсгалч нарыг хоорондон нь эвдрүүлээд завсраас нь Рибэн авч залгисугай хэмээмой.

Жич, Вашингтоны хуралд Монголыг мөн Солонгос лугаа адил илэрхийгээр хэлэлцсэнгүй болой. Үүнд, энэхүү Вашингтоны хурлын явдлаас хэрэгтэй юм үгүй хэмээн та нар ч мэдсэнээс гадна, эдүгээ бас Итали улсын Генуя хотод их хурал нээхийг завдаж буй. Энэхүү хуралд Вашингтонд хэлсэн үг нэг мөсөн эвдрэх нь илэрхий болой. Гэвч энэхүү Генуягийн хурал нээгдэх ба эсэх хийгээд нээгдэх ахуул Алс Дорнодын хэргийг холбогдуулж хэлэлцэх үү, үгүй юу. Чухам юуг хэлэлцэх нь даруйдаа мэдэгдээгүй бөлгөө. Гагцхүү илэрхий мэдэх нэгэн зүйл бол Америк, Рибэн, Франц, Англи зэрэг дөрвөн хүчирхэг улсын эзэрхэг капиталтан нар засгийн эрхийг барьсан цагт хэрхэвч Дорнын олон ардын хэргийг сайнаар шийтгэхгүй болой. Учир нь саяын Вашингтоны хурал бөгөөс харин дэлхийн эзэрхэгүүд олон ардыг мөлждөгөө зөвшөөрөн баталсан ану болой.

Жич, өнгөрсөн 1914 оны Европын байлдаан бөгөөс энэхүү дэлхий дахиныг хуваан авахын төлөө үүссэн болой. Их байлдааны урьд үеийг байцааваас Английн капиталтан нэгэн хүмүүн бээр Гуулин улсын 800 хүнийг мөлжин сорж байсан тул түүнээс хойш эдүгээ хүртэл үүссэн тэмцэл ану цөм дэлхийг хуваан авахын учруудаас болсон бөгөөд жич, 1910 онд Рибэнд эзлэгдсэн Гуулин улс ба Ланчжао, Шаньдун зэрэг газрууд хийгээд Америкийн эзлэсэн Бали арал ба Английн олзолсон Энэтхэг мэтийн эзэлсэн газруудыг мөн Вашингтоны хурал эдгээрийг хэвээр Англи, Америк, Рибэнд эзлүүлсүгэй хэмээжихүй.⁹⁰ Би санаваас эдгээр харгис эзэрхэгүүд олз идшээ хэрхэн байна даа. Харин тус тусын эзлэн дарласан бага буурай улсыг зовоон мөлжихдөө харилцан туслалцсугай хэмээн хэлэлцсэн тул эдүгээгийн цагт эзэрхэг түрэмгий нар Вашингтонд сүлбээлдэн байхад эртний мэргэн нөхөр Жарайши хэлсэн нэгэн зүйлийн хэрэгтэй үг байна.

⁸⁹ Пролетарийн хувьсгал ялсан орны туслалцаатайгаар бага буурай орнууд тусгаар тогтнолоо олж, хөгжлийн капиталист замыг алгасан социализмд хүрч болох тухай В.И. Лениний сургаалыг Монголд хэрэгжүүлэх бодлогыг оросын большевикууд анхнаасаа эхлэн баримталж ирсэн аж

⁹⁰ Вашингтоны бага хурлаар колони болон хагас колони орнуудын хувьд “Мандатын систем” гэдгийг буй болгож түүгээр нэлээд хөгжил бүхий колони орнуудад удалгүй тусгаар улс болох эрхийн мандатыг олгох, харин дунд хөгжилтэй орнууд бие даан хөгжих нөхцөл хараахан бүрдээгүй хэмээн үзэж “хагас мандат эзэмших” эрх олгож, харин бүүр буурай хөгжилтэйг нь бие даан хөгжих боломж нь ойрын ирээдүйд харагдахгүй байгаа орнууд гэх мэтээр ангилан үзэж Мандатын системд оруулсан юм.

Миний нөхөр бээр Европын их дайн үүсэхийн урьдаар дэлхийн олон улсын байдлыг сайтар шүүмжлэн мэдээд хэлсэн ану. Жич, их дайн үүсмой. Энэхүү дайн бөгөөд эзэрхэг харгис, баялаг ноёлог та нарт мэхлэн хэлэх ану: бид нар бага буурай улсуудыг аврахын тулд ихэнхүү дайн хийх болой. Би санаваас энэхүү дайн хэмээгч тэдгээр эзэрхэг муу харгисууд бага буурай улсыг эзэрхийлэн дарлах ба олсон олзоо хуваан авахаас болж тэмцэлдэж дайн үүсмой.

Жич, эдүгээх засгийн эрхийг барьсан эзэрхэгүүдийн хэлэлцэх ану “Би энэ хотын энэ бүлэг этгээдийг дээрэмдэн эзлэн суусугай. Чи тэр этгээдүүдийг дээрэмдэн эзлэн суухдаа, чамайг дээрэмдэхийн цагт нүдээ аниад байсугай” тэрчлэн адил энэхүү Вашингтоны хуралд мөн энэ төлвөөр хэлэлцэж ихүй. Юу хэмээвээс эзэрхэг харгис Рибэн бээр Америкад хэлсэн нь ану: “Чамайг өөрийн эзэлсэн улсуудаа дээрэмдэхэд би нэг нүдээ анин суусугай. Жич биднарыг Гуулин улсыг дээрэмдэхэд чи хоёр нүдээ аниваас зохимой” хэмээх зэргээр хэлэлцэж ихүй учир магуу иймийн тул. Алс Дорнодын ардуудыг удирдагч Эв хамтын нам ба нам бус хүмүүс ч энэхүү Вашингтоны явдлыг нэгч итгэхгүй болсон боловч үүнээс хойш чухам ямар учир болох ба, жич дарлагдан мөлжигдсэн буурай улсууд хэрхвээс эрх чөлөөгөө олох бол хэмээн асуухад хүрчихүй. Жич бидний энэ хуралд ирсэн олон улсуудын тус бүрдээ юу үйлдвээс зохих зүйлийг өгүүлсү.

Хятадулс өөрийн байдлыг шүүмжилбээс, эзэрхэг харгис түрэмгий нар бага буурай, зэр зэвсэг үгүй хийгээд эзэрхэгүүдийг хөнгөн гаргаж чадах үгүй улсыг хэрхэн дарлагдийг илэрхийгээр үлгэрлэн үзүүлэгч газар мэт болчихуй. Урьд 1900 оны үед Европын эзэрхэгүүд ба бидний Оросын эзэрхэг суртал хамтран сүлбээлж Думдад Хятадыг дарлан дайлан⁹¹ нь эзэрхэг харгисууд нэрээ бузарлаж өөрийгөө танигдуулсан болой. Түүнээс эхлэн тоолшгүй олон ардуудтай хятад хэдхэн эзэрхэг харгисийн эрх дарлалд орсныг санаваас эдүгээгийн Шанхай хотод бүхий нэг сая таван бум хоёр түм илүү хятад ардууд гадаадын харгис эзэрхэг капиталтан 2 түм хүмүүс, аймаг хүмүүс төчнөөн олон ардуудын ашиг шимийг сорон авч буй хэмээхээс гадна тэдгээр ард түмний эрдэм соёлыг ч элдэвчлэн доромжилчихуй.

Нөхөдөө, тэрхүү Англи, Америк, Рибэн, Франц нарын баялаг ноёлог харгис эзэрхэгүүд танай оронд явахдаа ташуур нударгаар танай улсыг хэв номхон ардуудыг занчин доромжлох хийгээд зоригоор заан танай газарт цэнгэлдэх цэнгэлийн хорио (янхны газрыг хэлж буй бололтой-Ж.У.) тэргүүтнийг байгуулан танай хүмүүсийг оруулах байтугай ойртуулахгүй ба бас танай улсын эхнэр охид тэргүүтнийг өгч их дарлах мэт амой. Хэцүү ичгүүрт муухай байдлыг би тамлан мөлжих, дарлах байдал нь улам дэлгэрсэн ану үнэхээр ертөнцийн адаг хэцүү ичгүүрт явдал мөн болой. Жич, танай Думдад улсын эдүгээгийн байдал нь маш олон анги болжээ.

⁹¹ Харийнхны түрэмгийллийг эсэргүүцэн Хятадын ард түмэн дэгдээсэн Ихэтуаны бослогыг (1898-1901) нухчин дарсны дараа Хятад руу гадныхан улам эрчимтэй нэвтрэх болжээ.

Бутрал салгуу харилцан тэмцэлдэх ба зарим мужуудын Чжан Цзолин⁹² мэтийн дээрэмчин хунхууз эзлэн давшдаг хийгээд зарим муж зальхай ван, гүн нар нь тус улсын хөрөнгийг сүйтгэдэг хийгээд улсын байдал улам хуучны бүдүүлэг бэлээр удирдан эртний хэрэггүй хоцорсон эзэрхэг магуухааны тахил босгож байгуулсугай хэмээх саналтай хийгээд энэ нь ч гадаадын капиталтан нар нэвтрэн эзэрхсэн ч Думдад улсын үйлдвэрчин ардуудын байдал маш доройтжихуй. Эдгээр хэмээгч цөм гадаадын харгис эзэрхэгүүд Хятадын хэрэгт гүнээ холбогдсоны учраас болой.

Үүнд бидний энэ хурал хэмээгч хэдэн улсын замыг удирдан зөвийг барьж явах гэсэн юмыг зааж өгөх хэрэгтэй болой. Гиймийн тул Хятадад эдүгээ бүтээх зүйлийн эн тэргүүнд түүний дотоодын олон зүйлийн хувьсгалт ардуудыг нэгтгэх хийгээд, жич бидний үйлдвэрчин ардууд Хятадад бүхий гадаадын эзэрхэгүүдийг үлдэн хөөн гаргах замыг танай ард түмэнд ухуулан хэлэх ану. Жич танай хүнд зовлонт байдлыг бид цөм мэдмой. Гадаадын эзэрхэгүүдийг Думдад улсаас дарлан мөлжсөөр 1920 онд нэгэн миллиардөртэй болжихуй. Эдүгээ Думдад улс хэдийбээр 200 түмэн цэрэгтэй хэмээвч үнэндээ зэр зэвсэг үгүй улс лугаа адил болой. Яагаад хэмээвээс гадаадын эзэрхэг харгисууд аливаа аргаар түүний цэргийг олон анги үзэлт болгож санал, хүчийг нь салгасны учраас болой.

Жич, өрнө зүгийн Европын капиталтан нар басчуу тийнхүү ард түмнийг өөрийн эрхэндээ нэг мөсөн оруулж дарлахын тулд христосын шажны хар лам нараас үлэмжхэнийг томилон оруулж түүний ардхүмүүнийг тэрхүү шашин суртал дор удирдасаар эдүгээ нижгээдхам ардтэдгээр христуудын хамааралдоржээ. Жич, тэдгээр хар лам нар энэхүү хорлолтой Вашингтоны хурлыг магтан хэлдэг нь буй за. Тэд нар болбоос нарийндаа танай хятадын ард түмнийг эзэрхэг капиталтны идэш болгох замд удирдагч этгээд болой. Миний хэлсэн нь танай улсын түгшүүрт байдал мөн хэмээвч үнэндээ нэгэн өнцгөөс үзэн төсөөлөн сонгосныг хэлснээс бус хичнээн олон буй зовлонт байдлыг таны олон ч мэдсээр буй за.

Эдүгээ басхүү танай улсад тэдгээр эзэрхэг харгисуудын гараас мултрахыг хүсэгчид үлэмжхэн болчихуй. Энэ нь гагцхүү танай улсын хувьсгалт намуудын санал бус болой. Танай улсын дарлагдан мөлжигдсэн ардууд цөм мөнхүү саналыг олжихуй.

Үүнд, миний бие эв хамтын Интернационалын өмнөөс хэлэх ану. Танай улсын олон түмнийг энэ эв хамтын саналыг гүйцэтгэх явдалд дэлхий дээр эв хамтын Интернационал бэр эртнээс алдаршсан гайхамшигт алдраа гийгүүлэн хиймой. Эрдэм чадлаа гаргаж эрслэн босож танай саналыг хүчитгэн эзэрхэгийн хорлол дарлалаас тонилох болой. Эв хамтын Интернационалын чухам санал ану

⁹² Чжан Цзолин (1875-1928)- Хятадын цэргийн зүтгэлтэн, генераллиссимус. Залуудаа дээрэмчин байсан боловч 1902 онд Чингийн армид хүчин зүтгэж явсан. Бээжингийн засгийн газар Юань Шикайг нас барсны дараа түүнийг фэнтяньны генерал-губернатор болон Зүүн хойтын гурван муж болох Ляонин, Цилинь болон Хэйлунцзяны захирагчаар томилсон байв

Америк, Англи, Рибэны харгис эзэрхэгүүд танай оронд олон түмнийг мал мэт дарлан явах ба жич танай эд хөрөнгийг илэрхийгээр дээрэмлэх зэрэг явдлуудыг тасалсугай хэмээмой. Урьд 1900 онд гадаадын эзэрхэгүүд танай улсаас гаргахад танай олон түмэн ардмах цусаа бартал мөнхүү өрийг төлсөөр бөлгөө.

Жич, Гуулин улсын явдлыг өгүүлбээс урьд бөгөөс Гуулин улсыг Орос, Рибэн хоёр хоорондоо булаалцалдан⁹³ агснаас эдүгээ цагт ганц Рибэны эзэрхэг дарлалд орчихуй. Бидний сонссон ану Гуулин улсаа тэтгэсүгэй гэсэн хэдэн мянган хувьсгалч хүмүүс эдүгээ Рибэны гянданд буй. Жич, мянга шахам сайн эрс Рибэн лугаа тэмцэлдэн сөнөөгдсөн хэмэжжихуй. Бас саяхан 1919 онд⁹⁴ танай Гуулин улс бээр тэдгээр харгис Рибэн лугаа их л байлдан тэмцэлдсэнийг би ихэд эрхэмлэн харсаар болой. Танай Гуулин олон түмэн ардыг Рибэн ба танай урвасан хэдхэн эзэрхэгүүд дарлан суудаг болой. 1917 оны үед үзвээс танай Гуулин улсад 332 000 Рибэн хүмүүс сууж олон сая Гуулин улсыг дарлан боолчилдог ажгуу. Үүнийг Рибэн нар омогшин санадаг ану. Бидний нэгэн хүмүүн Гуулингийн 99 хүнийг дарангуйлан захирч чадаж ахуй хэмээдэг. Бас Рибэн улс Гуулин улсын газрын нутаг, алт, мөнгө, чулуун нүүрс зэргийн уурхайг булаан авахаар удаа бүр тэмцэлджихуй. Жич, 1917 оны урьд Рибэн 33 сая төгрөгийн хөрөнгөөр Гуулингийн газарт үйлдвэрийн хашаа хороо байгуулж, үүнд Гуулин улс Рибэн нарыг хүчлэн хорьхуй аваас түүний харгисууд удаа бүр улам давшин орох болой. Эдүгээгийн Рибэн нар Гуулин улсыг дарлан байгаа нь урьд Англи улс Ирландулыг дарласан лугаа адил боловч Рибэн нар гуулинг нэн бүдүүлгээр дарлаж буй болой. Урьдын Англи улс хэдийвээр Ирландыг дарлавч ичгүүрээ мэддэг буй. Эдүгээгийн Рибэн улс Гуулин улсыг нэн ичгүүр үгүй дарлахад Гуулин улс эвүүцэх явдлаа улам ихтэй хөгживэй хэмээхуй ч байтугай энэхүү Рибэныг үлэмжхэн занаж буй. Эдүгээ жич бидний Интернационал бээр танай Гуулин улс эдгээр эзэрхдэг харгис түрэмгий нар луугаа эсэргүүцдэгийг сайшаан харгалзах атал бас танай зарим хувьсгалч нар харин Европын эзэрхэгүүдийн Вашингтоны хуралд эрмэлзэж, бидэнд эрх чөлөө олгох болов уу хэмээдгийг Интернационал их л уйдан гэмшдэг болой. Эдүгээгийн энэ хурал бөгөөс танай Гуулингийн бүх шударга хувьсгалч нарт үнэн учрыг ухуулж хэлбээс зохих зүйл ану. Танай Гуулин улс үүнээс хойш тэр мэтээр Европ, Азийн олон үйлдвэрчин ба пролетари ардуудаас гадуур эзэрхэг этгээд эдитгэдгээ олон ардын үзлээс зайлуулбал зохимой.

Монголын⁹⁵ явдлыг өгүүлбээс ойроос Монголыг Хятадад эгүүлэх явдал гарах магад бус уу гэж би урьд хэлсэн ба бас Монгол улсыг эзэрхэг харгис

⁹³ 1907 онд Япон-Оросын хэлэлцээрийн нууцлагдсан хэсэгт Хаант Оросын тал хойшид Япон-Солонгосын маргаантай асуудлуудад оролцож байхгүй гэсэн заалтыг оруулсан байсан боловч Солонгос 1910 онд Японы колони орон болсны дараа Орос-Солонгосын хилийн асуудлаас болж Япон-Оросын хооронд зөрчилтэй асуудлууд үүсдэг байжээ.

⁹⁴ “Туравдугаар сарын нэгний хөдөлгөөн” хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн Японы колоничлолыг эсэргүүцсэн тэмцэл ялагдлаар төгсөж, Солонгосын хувьсгалчид Хятад руу дүрвэн гарчээ.

⁹⁵ Монголын залуучуудыг төлөөлж С.Буяннэмэх үг хэлжээ.

улсууд хоорондоо бөмбөг наадах мэт болгожихүй хэмээн хэлсэн болой. Үүнд, эээрхэг этгээд бөгөөс бага улсын өөртөө засах эрхийн зах зухаас гаргахад нэн ч болгоомжлох бөгөөд тэдгээр Рибэны харгисууд ч тэдэнд тустай аваас ямар мэтийн муухай явдал үүсгэхийг өчүүхэн ч ичихгүй. Тэрчлэн өмнө Хятадаас даруйдаа Монголыг эргүүлэн авмой хэмээн эндүү санал гаргах ахул маш их алдагдал болно хэмээн надад санагдмой. Жич, Думдад улсын эрдэмтэн авгай нар ба хувьсгалч нар хэзээ засгийн эрхээ авч, ардын зарлигийг бүтээхийн цагт сая Хятад, Монголын явдал үйлс найрамдалтайгаар шуудрах болой. Тэр цагт сая монголчууд хятад лугаа хэрэг үйлсээ хэлэлцэх ану зохимой. Эдүгээгийн цагт бөгөөс Хятадын өмнө мужийн хувьсгалч засгийн газар бөгөөс гадаадын эээрхэг харгис ба эдүгээ эрх барьсан дотоодын олон харгисуудад бөглөгдөөд тэдгээрийн гараас гарч чадах эсэхээ ч мэдээдүй ба жич эээрхэгүүд лүгээ эсэргүүцэн байлдаан ану дийлэх, дийлэгдэхийгээ мэдээд бас Хятадын дотоод байдал ану олон анги бутарсан энэхүү цагт өмнө мужууд Монголыг эгүүлсүгэй хэмээвээс маш алдагдлын туйл болох бөгөөд уламжлан Хятад, Монголд ямархан гамшигт учралдаж болов уу хэмээвээс нэг нь ард нөгөөгөө дарлаваас тэр дарлагдсан этгээд бээр эрх чөлөөтэй болж үл болмой. Энэ мэтийн хэлснийг Алс Дорнодын ардууд марталгүй хадгалбаас зохимой. Ер хүмүүн бээр бусдад дарлагдваас сая дарлагдсан улсын зовлонг мэднэ. Хэрэв дарлагдлаас салбаас мөн нөгөөгөө дарлан суух учирч байдаг болой. Энэхүү учир бидний Орост ч гарсан тул үүнээс үлгэр авч Думдадулсын хувьсгалч нарт мэдтүгэй хэмээн дуулгах ану болой. Тиймийн тулд Думдад эрдэмтэн авгай нар Рибэн ба бусад харгисуудыг эрх дархаас мултрахыг эрмэлздэг бөгөөд, түүнчлэн Монголыг ухамсарлан мэдэж эрх чөлөөтэй болговоос зохимой.

Эдүгээ миний өмнө сууж буй Дорно зүгийн дарлагдсан ард түмний төлөөлөгчид та нарын санал зорилго ч энэхүү урьдын хэлсэн лугаа адил байжихуй. Жич, бид нар энэхүү хуралдаан бас ч Дорнодын олон улсыг дарлан зовоогч Рибэны ардын төлөөлөгчийг уриад эдүгээ бидний дэргэд сууна буй. Хамтын Интернационал Дорнын хэргийг шийтгэхдээ үнэн зөвөөр явуулж бүхий ану илэрхий бус ав уу. Жич, энэхүү Алс Дорнодын аливаа хэргийг шийтгэхдээ эээрхэг Рибэнээс гадуур эл шийтгэж болох тул танай Дорнодын ардууд эрх чөлөөгөө олохын түлхүүр ану харгис Рибэны ард түмний гарт буй. Бидний энэ хуралд Рибэны ардын төлөөлөгч сууж байгаа нь Дорнодын олон ардын хэрэг хялбархан бүтэхийн тэмдэг болой. Жич, эдүгээгийн харгис Рибэн улсыг бөгөөс Дорнодын олон улсын анх удирдлагын эээрхэг харгис улс хэмээгддэг тул энэхүү нэрд Рибэны капиталтан их л бардан баяртай байдаг бөгөөд өөрсдийн үйлдвэрчин ардад бидний улс их нэртэй болж буй хэмээн хэлдэг ану. Урьдын Англи улс ард түмнээ мэхэлдэг арга лугаа адил болжихуй. Тэрхүү Англи ард түмнээ муусурталд удирдсанаас түүний ардуудын зарим нь Ирланд улсын эрх чөлөө хүсэх явдлыг муушаадаг ч байдаг тул тэрхүү байдал нь гадаадын үзэлд маш гажуу байдаг

ану. Тэр ч байтугай бид нуух газаргүй тэдний эв хамтын сурталд үйлдвэрчин ард ч Ирланд улсын эрх чөлөө хүсэх явдалд мөн ч дургүй байдаг болой. Урьд тавин оны цаадах Маркс⁹⁶ өгүүлсэн нь: Английн ард Ирландын ардад эрх чөлөө олгохгүй байгаа аваас түүний ард ч эрх чөлөөгөө олж чадахгүй. Жич, тэрхүү харгис Английн ардууд хэдийгээр амандаа Ирландын ардуудад эрх олгоно хэмээдэг боловч, уг санал нь үнэн үгүй бөгөөд эдүгээгийн харгис Рибэн мөнхүү ёсоор өөрийн ардаа мэхлэн хуурч, бусад бага буурай ард эрх чөлөө олох явдалд дургүй бодлоготой болой. Тийм боловч харгис Рибэны залуу идэр үйлдвэрчин ард бээр тэдгээр харгис эзэрхэгүүдийн аргыг сонсохгүйгээр эсрэг тэсрэг тэмцэлддэг тул тэдгээр эзэрхэг капиталт магуу харгисуудыг мэхлэлд хэрхэвч орох үгүй буй за хэмээн бид итгэмой. Тиймийн тул энэхүү хуралд танай олон ардууд лугаа сайн журмаар учирсан билээ. Харгис эзэрхэг капиталтан Рибэны ардад ухуулан сургах ану. Бидний Интернационал эдүгээгийн дэлхийн олон улсын байдлыг үнэнээр мэдэж бүхий тул танай Рибэны харгис капиталтан нар харгис эзэрхэг Франц, Англи ардуудаа мэхэлдэг аргыг сурч буй билээ. Та нар яавч тэрхүү харгисуудын муу арганд орж хэрхэвч үл болмой.

Урьд Марксын хэлсэн нь буй: харгис эзэрхэг Англи улсад хувьсгал гарах аваас бүх Европ тив хувьсмой. Харгис Англи хувираагүй байвал аяганы доторх ус цалгисан лугаа адил хэмээжихүй. Тэрчлэн адил Алс Дорнодын олон улсад харгис эзэрхэг Рибэн улс хувисваас бүх Ази тив хувьсмой. Эзэрхэг харгис Рибэн улс хувьсах цагт бусад улс эрх чөлөөгөө олж чадах тул бүх Дорнодын олон улсын ганц түлхүүр нь эзэрхэг харгис Рибэн улсын гарт болой. Үүнд, болбоос бүх Дорнодын ард түмнийг удирдан жаргуулж чадах нь гагцхүү харгис эзэрхэг Рибэны залуу ардад байх болой. Энэхүү цагаас уламжлан та нар харгис эзэрхэг ноёлог баялагуудын арганд орж урвалгүй, хүчлэн оролдох цагт танай биед оржихуй. Бид их харгис эзэрхэг Рибэны дотоод худалдаачин ардуудын байдлыг сайн мэдэхгүй болой. Тэр ч байтугай түүний ардуудтай сая учирч байна. Бидний сонсоход түүний хөдөлмөрчин ард омогшил сэргэж эзэнт засаг юугаан унагаах ээ эвийг олж⁹⁷ буй хэмээн сонгогдох хэмээмой. Гэвч лавдалтай бус хэлэх төдий л аягтай буй боловуу за. Харин түүний хөдөлмөрчин ардууд гурван сая буй. Тариалангийн ард таван сая амьдармой хэмээх бөгөөд бас Өрнийн эзэрхэг харгис Рибэны капиталт улам хөгжин бадарч байх цаг бөгөөд санаваас түүний ардууд

⁹⁶ Карлс Генрих Маркс (1818-1883)- Германы гүн ухаантан, эдийн засагч, социологич, зохиолч, яруу найрагч, нийгмийн зүтгэлтэн. Философийн зохиолууд нь диалектик ба түүхэн материализмыг, эдийн засгийн сургаал нь нэмүү өртгийн онолыг, улс төрд ангийн тэмцлийн тухай онолыг буй болгосон бөгөөд эдгээр нь коммунист хийгээд социалист хөдөлгөөний үндэс, үзэл суртлын зэвсэг болж “Марксизм” хэмээн нэрлэгдсэн юм.

⁹⁷ Японы коммунист нам 1922 оны 7 сарын 15-нд Токио хотноо зүүний гурван бүлэг болох Гёоминкай, Мокүёакай, Сүйёкай гэх анарх-синдикалист үзэл бүхий хүчнийхэн нэгдсэнээр байгуулагдсан. Алс Дорнодын коммунист болон хувьсгалч нарын анхдугаар хурлаас (бидний өгүүлэн буй хурал- Ж.У) хойш Коминтернд нэгдэх чиглэл баримтлах болсон

гүйцэлдэн хүмүүжиж чадуудай.

Чухам учир утгыг мэдсэн эв хамтнам ба бус намуудануцөм тус бүрдээ 100 шахам гишүүн хүмүүнтэй буй. Өнгөрсөн 1918 онд ээрхэг харгис Рибэны дотоодод хувьсгал гарснаас⁹⁸ хойш түүний капиталт бус хувьсгал үзээгүй бөлгөө. Ээрхэг харгис Рибэны чухам байдлыг өгүүлбээс, хөгшин төлөгч эмгэн ингэж хэлэх лугаа адил, чиний морь маш сайн бөгөөд чиний хөрөнгө ихэд дэлгэрч их хүчит болох буй хэмээх мэт. Бид санаваас түүний хөрөнгө хөгжихийн сацуу түүний хөрөнгө ээрхэхийг устгах хөдөлмөрчин ард ээргээр хөгжиж тэдгээрийг бадаргуулах болвуу. Түүнээ мэдээдэй болой. Тиймийн тул эдүгээгийн түүнчлэн харгис ээрхэг Рибэны ард иргэний байлдаан мөн их л гарч сүйтгэл болоод, хөдөлмөрчин ардууд нь эрхээ олох буй за хэмээсэн нь маш үнэн болох бололтой. Тиймийн тул харгис ээрхэг Америк, Рибэны ардууд цөм нийлж эрх чөлөөгөө олж, ээрхэг харгис капиталтнаа арилгаж чадваас сая энэхүү яригтай их байлдаан үүсэж дэлхийн амьтанд цусан аюулт их гамшиг болох хийгээд хүмүүн төрөлхтний бүтээсэн их эд хөрөнгө сүйтгэхийн зовлонгоос сая гэтэлгэвээс зохимой. Энэхүү учраас Хятад, Гуулин, Монголын хэдэн зуун сая ардын эрх чөлөө, энх жаргалангийг олохын тобч түлхүүр нь ээрхэг харгис Рибэны ард түмэнд буй хэмээгч энэ болой.

Манай энэ хурлын зорилго болбоос бүх Дорнодын ард олны саналыг Рибэний үйлдвэрчний саналтай хувьсган нийлүүлэхийг хүсмой. Эдүгээгийн та нарын хэлэлцсэн үгсийг⁹⁹ эцэст дахин танай ард түмэн ч хэлж чадахад хүрэх билээ. Эрхэтгүй энэхүү цагаас тар нар сэтгэл санаагаа харилцан танилцуулж, бат итгэмжийг тогтоох аваас сая танай олон ард Рибэны ардууд лугаа сэтгэл хүчээ нэгтгэж чадмой. Тийм аваас бусадхэргийг чинь эв хамтын Интернационал биедээ үүрч эрхэтгүй бүтээн өгөх болой.

Ээрхэг харгис капиталтан Англи, Америкийн ардуудлугаа танай Дорнодын олон ардын санал зорилгыг нийлүүлэх явдалд Интернационал эрхэтгүй бүтээн өгөх болой. Эв хамтын Интернационал туг дээрээ бичсэн ану “Бүх дэлхийн хувьсгалыг хөгжүүлмөй” хэмээн бичсэн болой. Энэ нь гагцхүү Европыг хэмээсэн бус болой. Тиймийн тул Алс Дорнодын олон ардууд ба Европ, Америкийн үйлдвэрчин хамаг ардууд нийт санал хүчээ нэгтгэх явдлыг бид нар үйлдэх боловч хамтран нийлэхийн жишээ нь та нараас гарах бөгөөд Европ Азийн ардуудын ашиг тусыг мэдэж таньж авахын явдал ч та нараас гарах болой. Танай Алс Дорнодын олон ардуудын үг санал нь тус тусдаа үндэс язгуур бээр тасран салж тусгай улс байгуулахын зорилготой тул танай энэ зорилго хэмээгч чухам эв хамтын үзэл суртлыг дагасан

⁹⁸ 1918 оны 7-10 сард “Будааны бослого хөдөлгөөн” гарч, будааны үнэ огцом өссөнийг эсэргүүцэн ард түмний гаргасан нийгмийн хөдөлгөөн. Японы 47 мужийн 42-т нь гарч 10 сая хүн оролцжээ. Ерөнхий сайд Тэраүчи Масатакэ нийгмийн дэг журмыг сахиулж чадаагүй хэмээн өөрийгөө буруутган 1918 оны 9 сарын 29-нд огцрох өргөдлөө өгснөөр түүний кабинет унажээ.

⁹⁹ Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хуралд оролцсон орнуудын төлөөлөгчид өөрийн орны байдлын тухайд тус бүр илтгэл тавьсан.

нь бус боловч ардын засагтай улс болж, ард түмний эрх чөлөөг бадруулахын дүрэм тул нийтээр турхиран хөдөлж мөнхүү зорилгыг гүйцээхийг завдах буй. Гэвч танай ард түмний байдлын зарим нь чухам пролетари ардын явдал лугаа нийлэх эсэх нь мэдэгдэхгүй боловч эцэсдээ эрхтгүй нийлэх учиртай болой хэмээхээс гадна эв хамтын Интернационал бээр үүсгэснээс инагш энэхүү пролетари ба нийтардуудын саналыг нэгтгэхийг оролддог бөгөөд Интернационалын хоёрдугаар дэлхийн их хуралдаандаа¹⁰⁰ бүх дэлхийн дарлагдсан улсуудын тухай онцгой зүйл гаргаж хэлэлцсэн бөлгөө. Жич, та нар энэхүү хуралд тус тусын намын үзэл суртлаа хэлэлцэх зорилтод миний хэлэх явдал үгүй хэмээжихүй. Миний бие эдүгээгийн дэлхийн олон улсын чухал нууц байдлыг шүүмжлэн үзэхэд таны энэ хуралд нийлүүлээд харин юуг нь хэлэлцэх зүйлийг заан өгөх хэрэгтэй болой.

Миний мэдсэнд, эв хамтын Интернационалын их чуулганаар 1920 онд дэлхийн их хурал нээж хэлэлцсэн зүйл дотор тэмдэглэсэн нь: аливаа эв хамтын сурталтан бээр гагцхүү дэлхийн олон ард улсыг тэгш эрхтэй болгохыг зоримой хэмээсэн бусуу, цөм бас боловсруулан шинэ байдалтай болгоод хуучиндаа бид маш бүдүүлэг агсан ажгуу хэмээх байдлыг нь илтгэн үзүүлэхийг эрмэлзмой хэмээжихүй. Жич, хөрөнгөтний засагтай улс бээр мөн хэлэх ану бүх дэлхийг тэгш эрхтэй болгомой хэмээдэг боловч хийх ажилдаа мөлжих дарлахаа урьдал болгох болой. Үүнд, эв хамтын Интернационалын хоёрдугаар их хуралд ирсэн 42 улсын эв хамтын намууд эрс тасархай шийтгэсэн нь дэлхийн аливаа дарлагдсан ардууд эрх чөлөөгөө олохыг хүсвээс Зөвлөлт Орос улс лугаа итгэмжлэн нийлэхтүн хэмээсэн бөлгөө. Тэрхүү 42 улсын эв хамтын намууд энэхүү үгийг хэлэх, дахин Зөвлөлт Оросын үнэн явдлыг магадлан мэдээд хэлсэн болой. Тийн хэмээвч бидний Зөвлөлт Орост мөн ч засамжлаагүй, шийтгэх хэрэг бас ч байдаг боловч чухал үндэс ану нөгөөгөө мөлжихийн муу суртал арилсан болой.

Бидний Зөвлөлт Орос урьдын эзэрхэг харгис засгийн элдэв мууг маш хялбархан устгасан билээ. Эдүгээ манай улс дахь эртнээс дарлагдан агсан буриад зэрэг улсад өөртөө засах эрх олгох явдлыг таван мөчийн хооронд гүйцэтгэн шийтгэжихүй. Тэрхүү бидний ардын эзэрхэг харгисаас салан байхын цагт хичнээн олон үндэс язгуурын улс туйлаар дарлагдан маш хүнд зовлонтой агсдагаас манай Оросын хөдөлмөрчин ардууд засгийн эрхээ эзэлж үнэн шударгаар олон түмэнд тустай хэргийг бүтээсэнд удсангүй хэдэн сарын дотор цөм харилцан найрамдаж чаджихүй. Үүнээс нэгэн зүйлийн санал бүрэлдэв, юу хэмээвээс, зарим эзэрхэг харгис улсын дарлалдолон зүгийн улс буй харилцан тэмцэлдэх байдлыг нь хөнгөлөх арга үгүй аваас даруй дарлагч эзэрхэг капиталтан нар нь арилгамагц тэдгээр олон үндэстэн улс эрх чөлөөгөө биеэр баясгалантайгаар харилцан найрамдахын учралыг олох болой хэмээн мэдвээ. Энэ мэтийн учралуудаас ч эв хамтын

¹⁰⁰ Коминтерны II их хурал 1920 оны 7 сарын 19-ээс 8 сарын 7-ны өдрүүдэд Петроград хотноо хуралдаж, капитализмыг түлхэн унагаж ажилчин ангийн дарангуйлал тогтоон, бүх дэлхийн Зөвлөлт Бүгд Найрамдах улс байгуулах зорилтыг дэвшүүлжээ.

Интернационалын хоёрдугаар их хурал бүх дэлхийн хамаг дарласан улсуудыг Зөвлөлт Оросын журамт засгийг уламжлан авахтун хэмээн ярин дуудсан болой. Тийнхүү энэ мэтээр дэлхийн хоёрдугаар их хуралд шийдсэн билээ. Та нар ч юу хэмээн санаж байгаагаа илтгэн гаргах хэрэгтэй. Жич, танай ард улсуудын зарим нь бүдүүлэг байдалтай ба басчуу зарим нь үйлдвэрийн ард үгүй бол танай олон ард бүгдэв хамтын журмыг эрмэлздэг үгүй бөгөөд гагцхүү эрмэлзэх нь гадаадын эзэрхэгүүд ба дотоодын харгис хүчний эрхээс салж эрх чөлөөгөө олсугай хэмээн эрмэлздэг нь нэн зүйтэй боловч харин эцсийн цагт эзэрхэг харгис Рибэн, Америк, Английн хөдөлмөрчин ардуудын эв хамтын үзэл лугаа таны үзэл санал бас эс нийлбээс тэр харин маш бэрх түгшүүртэй явдал болох билээ. Бид нар басхүү тийнхүү эв хамтын суртлыг үүрд дагаж явах ба дэлхийн олон ард бүхнийг ч үүндээ удирдахыг хичээмөй. Орчлонгийн улаан тоосон дээр учрагч хамаг зовлонт амьдрал, эрх чөлөөгөө хүсч тэмцэлдэгч хувьсгалыг бид нар чин үнэнхүү ч хошилцон нөхөр болж явах болой.

Жич, Рибэн, Гуулин, Хятадын эв хамтын намд ухуулан сургах ану. Та нар тийнхүү язгуур улсаа тэнхрүүлэн эрх чөлөөгөө хүсч хөдөлсөн олон түмэн ардыг тэд лугаа туслалцан хамт хөтөлцөхийг мэдтүгэй. Юу хэмээвээс тэдгээр олон түмэн ардуудыг үндэс язгуураа сэргээн, эрх чөлөөгөө олох явдлыг тэдгээр эзэрхэгүүдийн Версаль, Вашингтоны хурлаар хүчитгэн шийтгэхгүй билээ. Өөрсдийн эв хамтын үйлдвэрчин ардууд түүнийг шийтгэж чадах билээ. Жич, өөрийн улс, ард түмнээ төлөөлөн санаж эднарт ухуулах ану. Та нар хэрвээ улсаа тусгаар эрхтэй болгосугай хэмээвээс хэрхэвч тэрхүү эзэрхэг харгисуудын Вашингтоны хурал хийгээд капиталт хөрөнгөтөн нарт бүү итгэхтүн. Гагцхүү танай эрмэлзэх зүйл бүтэхийн зам нь пролетари ардын удирдлагыг дагаваас зохимой. Тийм бүх эрх чөлөөгөө олохгүйгээс гадна эс дагаваас үүрд эрх чөлөөгөө олохгүйгээс гадна алсдаа эзэрхэг харгис Рибэн, Америк, Английн боол болж дарлагдал хүлээх болмой. Тиймийн тул танай олон бага буурай улсууд ба Хятад, Гуулин, Монголын хэдэн зуун сая ардууд гагцхүү бүх дэлхийн үйлдвэрчин пролетари ардууд лугаа сэтгэл санаагаа танилцуулж үнэн журмаар барилдах аваас сая амар жаргалыг эдлэх болмой. Эс танилцваас эзэрхэг харгис Рибэн, Америкчуудын хөл дор гишгэгдэн хоригдож хоосрох болой. Энэ мэтийг шалгарсан уран мэргэн хүмүүн санаагаараа гаргасан бус бөгөөд чухам эдүгээгийн дэлхийн байдал ба цагийн улирал үүнд хүргэсэн болой.

Жич, бидний эв хамтын Интернационалын өмнөөс та нарт ухуулан сэнхрүүлэн сургах ану. Эдүгээ энэхүү хуралд цугларсан таны олон улсын уг зорилгыг үзвээс хоёр анги шалтаг буй. Нэг нь, үйлдвэрчин ардуудын журмаар улсын дотоодын их эзэрхэг капиталтан ноёлог баялаг нарыг түлхэн унагаагаад засгийн эрхийг авсугай хэмээмөй. Нөгөө нь, гадаадын харгис эзэрхэгүүдийн гараас мултарч, тус улсын эрх чөлөөгөө дэлгэрүүлэхийг гүйцэтгэмөй. Ийм мэтээр та нар хоёр зүйлийн бодлоготой байх тул хэрвээ эцэстээ дахин санал зорилгоо

нэгтгэж чадахгүй аваас бас ч гамшиг болох бөгөөд энэ ч эзэрхэг харгисуудын мөлжих завшааныг үлдээнэ. Хэрвээ бидний энэ хуралд энэ мэтийн тасарсан хүчийг нийлүүлэх санал, бодлогыг нь олж шийтгэх аваас хойт үеийн өдөр тивд сайхан алдартай болох болой.

Эрхэм эрдэмтэн нөхөр Ленин¹⁰¹ өгүүлсэн нь: Алс Дорнодын олон ардхэмээгч дэлхийн хувьсгалч байгууллагуудын эцсийн хүчит этгээд нь билээ. Энэ үг минь санасан хоёр үгээ нийлүүлчихүй. Эдүгээ Зөвлөлт Орос хэмээгч дэлхий дахины шинэ хувьсгалыг хөгжөөн өдөж чадаад түүнээ сахин суусаар буй билээ. Энэхүү чухал цагт Европ тив даяар хувьсгалын гал бадарч, Алс Дорнын нэгэн тивийн ард хөдлөх үгүй аваас мөн ч өчүүхэн хувьсгал хэмээвээс зохимой. Жич, танай энэ хурал тоон өчүүхэн боловч хөндсөн хэрэг нь хүндчухал болой. Эдүгээгийн дэлхийн эзэрхэг харгисууд эвлэн үгсэж Вашингтон мэтийн хотод хуралдсан хийгээд өдгөө бас Итали улсын Генуя хотод дахин хурал нээх гэж байгаагийн чухам бодлого нь бидний Зөвлөлт засгийг залруулахгүй бөгөөд танай Дорнодын олон ардыг ариун шударгаар удирдагч этгээдийг завсарлагаад завшаанд нь залган орсугай хэмээх чухал цаг доорхи бодлогыг та нар таньж мэдэх хэрэгтэй хэмээхээс гадна тэдгээр эзэрхэг харгис капиталтан нар ч толгой тархи нь төөрөлдөн, санаа сэтгэл нь самуурч, зэвсэгт хүч нь сандарч мөхөх болтугай. Тэд нар болбоос бидний энэ хөрөнгө эс бүхий жигд хөгжил дэлхийн ардыг хөдөлгөж чадах буй эсвээс бид нар энэхүү эрхээ дахин хоршин буй хэмээн юугаан мэдэхгүй болно. Тиймийн тул таны саналд энэ мэт тэнсэн эзэрхэгүүдийн алинд нь суухыг хүсэн санах буй. Үүнд, таны Дорно зүгийн олон ардууд мөн ч урьдын адил өөрсдийн эзэрхэг харгис капиталтан нарын муу арга дор унаж нойрондоо ташууран хөдөлж ядуу байхаа эртхэнээс халж эзэрхэн, хурц эрсүүдийн тусаар хөгжин мандан Дорно зүгийн олон ардуудыг зоримгоор элсэн удирдаж, эрхэндээ нэг мөсөн оруулж дэлхий дахины хамтын Интернационалыг дэлгэрүүлэн хамаг амьтны тусыг бүтээхийн тулд үхэх, сөнөх усан галаас зайлалгүйгээр явж энэ дэлхийг мөлжин дарлагч зовоогч эзэрхэгч харгис ноёлог баялаг бүхнийг устган арилгаж, дэлхий дахины улс бүхнийг эрхэндээ хурааж, гайхамшигтулирлыг олноор үзэж биеэр өнгөрүүлэх минь болтугай хэмээн ерөөл тавин тархааваа.

¹⁰¹ Владимир Ильич Ленин (1870-1924)- Орос, Зөвлөлтийн улс төрийн ба төрийн зүтгэлтэн, хувьсгалч, Оросын ажилчны социал-демократ (большевикуудын) намыг үндэслэгч, 1917 оны Октябрийн төрийн эргэлтийг удирдан зохион байгуулагч, дэлхийн анхны социалист улсыг үүсгэн байгуулагч. Марксист, нийтлэгч, Марксизм-Ленинизмийг үндэслэгч. Коминтерныг үүсгэн байгуулагч, социалист байгуулалтын онолч.

Зохиогчид

1. Л.Алтантөгс. Намжилчойжилын Алтантөгс, Улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, БНХАУ-ын Жилин их сургуулийн докторант.
2. Г.Баярмаа. Гомбын Баярмаа, МУИС-ийн тэнхимийн докторант.
3. Т.Етекбай. Керей-Ители Татегийн Етекбай, СУИС-ийн докторант.
4. Ц.Жамбалсүрэн, Цэенноровын Жамбалсүрэн, МУИС-ийн Түүхийн тэнхимийн зөвлөх профессор.
5. Э.Лонжид. Харнууд Зоригтын Лонжид. МУИС-ийн Түүхийн тэнхимийн зөвлөх профессор.
6. К.Мацүда. Мацүда Коичи (Matsuda Kōichi, 松田孝一). Япон улсын Осака олон улсын сургуулийн хүндэт профессор.
7. Х.Мөнхбаяр, Тайжууд Халтарын Мөнхбаяр. Улс Төрийн Талаар Хэлмэгдэгсдийн Судалгааны Төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, МУИС-ийн докторант.
8. Х.Мэндсайхан. Хатанбатын Мэндсайхан, Монгол Улсын Цагаатгах Ажлыг Удирдан Зохион Байгуулах Улсын Комиссын Судалгааны албаны эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D).
9. Б.Нацагдорж. Цонгоол Батцэнгэлийн Нацагдорж. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Япон улсын Васэда их сургуулийн докторант.
10. Л.Одзаяа. Лахавасүрэнгийн Одзаяа, БХИС-ийн багш, МУИС-ийн докторант.
11. В.Т.Тепкеев. Владимир Толтаевич Тепкеев, ОХУ, ШУА-ийн Хүмүүнлэгийн ухааны Халимаг дахь хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан.
12. Улаанбарс, Чимэд Улаанбарс (Qi guan, 齊光). БНХАУ-ын Фүдан их сургуулийн Түүх, Газарзүй судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D).
13. Ж.Урангуа. Хэрээд Жамсрангийн Урангуа. МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор.
14. Л.Чулуунбаатар. Лувсандоогийн Чулуунбаатар, МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор.